

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2025 оны 07 дугаар сарын 01-ний өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-5

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 6-31

1.Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ/	6-12
2.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/	12-31

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны
07 дугаар сарын 01-ний өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэл ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 15 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 86.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 18 цаг 20 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Д.Бум-Очир;
Тасалсан: Н.Алтаншагай.

Нэг.Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Ундрэм, Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Монгол Улсын Ерөнхий аудиторов орлогч З.Цэдэнжав, Үндэсний аудитын газрын Санхүү, нийцлийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, мөн газрын аудитын менежер П.Чанцалдулам, С.Нацагдорж, Д.Энхдалай, И.Эрдэнэцэцэг, ахлах аудитор Ц.Батсүх, П.Батцэцэг, А.Даваадорж, Ж.Нямцэцэг, Б.Эрдэнэзул, Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Энхболд, мөн газрын аудитын менежер Ю.Энхтуяа, ахлах аудитор У.Оюунхүү, аудитор Б.Идэрбалжинням, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын М.Санжаадорж, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, мөн хэлтсийн ахлах мэргэжилтэн Ж.Төгөлдөр, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, мөн хэлтсийн ахлах мэргэжилтэн П.Энхманлай, мэргэжилтэн Б.Очиртогтох, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, мөн хэлтсийн мэргэжилтэн Б.Анар, Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга Б.Амарбаясгалан, Төлбөр, Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн Т.Хонгор, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогын газрын дарга Д.Баттогтох, Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Салбар дундын зохицуулалт, төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Мөнгөнсүх, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлтсийн дарга О.Мөнхтөр, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Батжаргал, мөн яамны Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга П.Оюунаа, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга С.Должинсүрэн, Санхүүгийн хэлтсийн дарга Э.Адъяасүрэн, Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Х.Тамираа, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын

яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Оюунбилэг, мөн яамны Соёл, урлагийн газрын дарга Э.Цэнд-Аюуш, Стратеги, бодлого, төлөвлөлтийн газрын дарга Н.Мөнхзул, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Отгонбат, Соёл, урлагийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Сэргэлэн, Соёлын өвийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Даваацэрэн, Биеийн тамир, спортын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Жаргалсайхан, Залуучуудын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Т.Батдорж, Мэдээлэл сурталчилгааны хэлтсийн дарга Р.Цээноров, Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга А.Амгаланзаяа, Аялал жуулчлалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын шинжээч Н.Болормаа, Татварын ерөнхий газрын дарга Ч.Чимидсүрэн, мөн газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга Р.Мягмаржав, Боловсролын ерөнхий газрын дарга Т.Ням-Очир, Боловсролын зээлийн сангийн дарга О.Сийлэгмаа, Биеийн тамир, спортын улсын хорооны дарга Э.Билэгт нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, референт Н.Монголмаа нар байлцав.

Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн талаарх илтгэлийг Сангийн сайд Б.Жавхлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн нар танилцуулав.

Илтгэл болон аудитын дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун, Д.Рэгдэл нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Боловсролын сайд П.Наранбаяр, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Ундррам нар хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Хэрлэн Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 18 цаг 47 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Ундррам, Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч З.Цэдэнжав, Үндэсний аудитын газрын Санхүү, нийцлийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, мөн газрын аудитын менежер

П.Чанцалдулам, С.Нацагдорж, Д.Энхдалай, И.Эрдэнэцэцэг, ахлах аудитор Ц.Батсүх, П.Батцэцэг, А.Даваадорж, Ж.Нямцэцэг, Б.Эрдэнэзул, Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Энхболд, мөн газрын аудитын менежер Ю.Энхтуяа, ахлах аудитор У.Оюунхүү, аудитор Б.Идэрбалжинням, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын М.Санжаадорж, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, мөн хэлтсийн ахлах мэргэжилтэн Ж.Төгөлдөр, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, мөн хэлтсийн ахлах мэргэжилтэн П.Энхманлай, мэргэжилтэн Б.Очиртогтох, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, мөн хэлтсийн мэргэжилтэн Б.Анар, Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга Б.Амарбаясгалан, Төлбөр, Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн Т.Хонгор, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогын газрын дарга Д.Баттогтох, Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Салбар дундын зохицуулалт, төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Мөнгөсүх, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлтсийн дарга О.Мөнхтөр, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Батжаргал, мөн яамны Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга П.Оюунаа, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга С.Должинсүрэн, Санхүүгийн хэлтсийн дарга Э.Адъяасүрэн, Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Х.Тамираа, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Оюунбилэг, мөн яамны Соёл, урлагийн газрын дарга Э.Цэнд-Аюуш, Стратеги, бодлого, төлөвлөлтийн газрын дарга Н.Мөнхзул, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Отгонбат, Соёл, урлагийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Сэргэлэн, Соёлын өвийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Даваацэрэн, Биеийн тамир, спортын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Жаргалсайхан, Залуучуудын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Т.Батдорж, Мэдээлэл сурталчилгааны хэлтсийн дарга Р.Цээноров, Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга А.Амгаланзаяа, Аялал жуулчлалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын шинжээч Н.Болормаа, Татварын ерөнхий газрын дарга Ч.Чимидсүрэн, мөн газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга Р.Мягмаржав, Боловсролын ерөнхий газрын дарга Т.Ням-Очир, Боловсролын зээлийн сангийн дарга О.Сийлэгмаа, Биеийн тамир, спортын улсын хорооны дарга Э.Билэгт нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, референт Н.Монголмаа нар байлцав.

Төсвийн төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Б.Жавхлан, төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн нар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Хосбаяр, Б.Хэрлэн, Ж.Галбадрах, О.Батнайрамдал, С.Эрдэнэбат, Д.Рэгдэл нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Боловсролын сайд П.Наранбаяр, Сангийн

яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогын газрын дарга Д.Баттогтох, Боловсролын зээлийн сангийн дарга О.Сийлэгмаа, Биеийн тамир, спортын улсын хорооны дарга Э.Билэгт нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Д.Рэгдэл: 1.Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрамын гаргасан, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн 35.3.1 дэх хэсгийн 35.3.1.1 дэх шалгуур үзүүлэлтийн аялал жуулчлалын салбарын хүний нөөцийг чадавхжуулах сургалтад хамрагдах хүний тоо “100.000” гэснийг “15.000” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам үг хэлэв.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 4
Бүгд: 13
69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрамын гаргасан, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний 35.3.2 дахь хэсгийн 35.3.2.1 дэх шалгуур үзүүлэлтийн аялал жуулчлалын салбарын өрсөлдөх чадварын үзүүлэлт /индекс/-ийг “78” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 4
Бүгд: 13
69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрамын гаргасан, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын хөтөлбөрийн үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлтийн 2025 онд хүрэх зорилт, түвшнийг “30 хувь” болгох гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 4
Бүгд: 13
69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлын гишүүн А.Ганбаатарын гаргасан, Төслийн 12 дахь хэсгийн 1.1.168 дахь төсөл, арга хэмжээний дүнг “541000264,7” төгрөгөөр бууруулж, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын Биеийн тамир, спортын улсын хорооны дотоодод зохиогдох олон улсын тэмцээний зардлыг “541000264,7” төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ганбаатар үг хэлж, Сангийн сайд Б.Жавхлан тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 6
Бүгд: 13
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Улсын Их Хурлын гишүүн Б.Хэрлэн, С.Эрдэнэбат нарын гаргасан, Боловсролын сайдын багцын бараа, үйлчилгээний зардлаас “5,8 тэрбум” төгрөгийг хасаж, төрийн өмчит боловсролын байгууллагад татаас хэлбэрээр олгох гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат, Б.Хэрлэн нар үг хэлж, Боловсролын сайд П.Наранбаяр, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Батжаргал нар тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 8
Бүгд: 13
38.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Хосбаяр Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 20 цаг 04 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 44 минут үргэлжилж, ирээл зохих 15 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 86.7 хувийн ирцтэйгээр 20 цаг 04 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
БОЛОВСРОЛ, СОЁЛ,
ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ч.УНДРАМ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 07 дугаар сарын 01-ний өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхим
18 цаг 20 минут.

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Рэгдэл: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, ирц 86,7 хувьтай бүрдсэн тул БСШУС-ын байнгын хорооны 2025 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье. Гишүүдийн ирцийг танилцуулаадахъя. Отгоншарын Батнайрамдал гишүүн ирсэн, Шинэбаярын Бямбасүрэн гишүүн ирсэн, Жанчивын Галбадрах гишүүн ирсэн, Амгаланбаатарын Ганбаатар гишүүн ирсэн, Гонгорын Дамдинням гишүүн ирсэн, Цэндсүрэнгийн Мөнхтуяа гишүүн ирсэн, Дүгэрийн Рэгдэл гишүүн ирсэн, Отгоны Саранчулуун гишүүн ирсэн, Мягмардашийн Сарнай гишүүн ирсэн, Чинбатын Ундром дарга ирсэн, Ганбатын Хосбаяр гишүүн ирсэн, Бадарчийн Хэрлэн ирсэн, Сүхбаатар Эрдэнэбат гишүүн ирсэн байна.

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 2 асуудал байгаа. 1 дүгээр асуудал Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл, 2 дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтийг Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ. 2 дугаар асуудал нь Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд, санал, дүгнэлтийг Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ. Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэг.Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ/

Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 24 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолыг хэлэлцэж эхэлье. Энэ манай хэлэлцүүлэгт хүрэлцэн ирсэн ажлын хэсгийг танилцуулъя. Сангийн сайд Жавхлан, Боловсролын сайд Наранбаяр, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ундром, Сангийн яамны ТНБД Ганбат, Эдийн засгийн хөгжлийн яамны ТНБД Батхүү, Боловсролын яамны ТНБД Батжаргал, Боловсролын яамны Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Оюунаа, Боловсролын яамны

Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Должинсүрэн, Эдийн засаг, хөгжлийн яамны Шинжлэх ухаан технологийн нэгдсэн бодлогын газрын дарга Баттогтох, Боловсролын ерөнхий газрын дарга Ням-Очир, Боловсролын зээлийн сангийн дарга Сийлэгмаа, Боловсролын үнэлгээний төвийн дарга Гантуяа, Боловсролын яамны Санхүүгийн хэлтсийн дарга Адьяасүрэн, Боловсролын яамны Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Тамираа, Соёл Спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Соёл урлагийн газрын дарга Цэнд-Аюуш, Биеийн тамир, спортын улсын хорооны дарга Билэгт, Соёл, спорт, аялал жуулчлал залуучуудын яамны Стратеги бодлого, төлөвлөлтийн газрын дарга Мөнхзул, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Отгонбат, Соёл, спорт, аялал жуулчлал залуучуудын яамны Соёлын өвийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Даваацэрэн, Биеийн тамир, спортын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Жаргалсайхан, Соёл, спорт, аялал жуулчлал залуучуудын яамны Гадаад харилцаа, олон улсын мэдээлэл, сурталчилгаа, хамтын ажиллагааны газрын Мэдээлэл сурталчилгааны хэлтсийн дарга Ц.Норов, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Залуучуудын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Батдорж, Соёл, спорт, аялал жуулчлал залуучуудын яамны Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Амгаланзаяа, Соёл, спорт, аялал жуулчлал залуучуудын яамны Аялал жуулчлалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын шинжээч Болормаа, Эдийн засаг, хөгжлийн яамны харьяа Шинжлэх ухааны академийн Тэргүүлэгчдийн газрын дарга Баярбаатар, ШУТС-ийн хэлтсийн дарга Тогтохбуян, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Тулга, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Дэлгэржаргал, Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга Цогбадрах, Сангийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын удирдлагын хэлтсийн дарга Бат-Эрдэнэ, Сангийн яамны Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга Мөнхсүх, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Ганзориг, Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга Гантогтох, Сангийн яамны Төрийн сангийн төлбөр тооцооны, Төрийн сангийн газрын Төлбөр, тооцооны хэлтсийн дарга Саруул, Сангийн яамны Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга Цагаанцэцэг, Сангийн яамны Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Сувд, Монгол Улсын Ерөнхий аудитор Магнайсүрэн, Монгол Улсын Ерөнхий аудиторовн орлогч Цэдэнжав, Санхүү-нийцлийн аудитын газрын менежер Энхдалай, Санхүү-нийцлийн аудитын газрын менежер Чанцалдулам, Санхүү-нийцлийн аудитын газрын менежер Нацагдорж, Санхүү-нийцлийн аудитын газрын менежер Эрдэнэцэцэг, Санхүү-нийцлийн аудитын газрын ахлах аудитор Даваадорж, Санхүү-нийцлийн аудитын газрын ахлах аудитор Нямцэцэг, Санхүү-нийцлийн аудитын газрын ахлах аудитор Батсүх, Санхүү-нийцлийн аудитын газрын ахлах аудитор Батцэцэг, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын аудитын менежер Энхтуяа, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын ахлах аудитор Оюунхүү, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын аудитор Идэрбалжинням. Ажлын хэсгийг танилцууллаа.

Нэгдсэн төсвийн 2024 оны гүйцэтгэл, Засгийн газрын 24 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Болдын Жавхлан хийнэ.

Б.Жавхлан: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн төслийн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг хуулийн хугацаанд нэгтгэн гаргаж, Төрийн аудитын төв байгууллагаар аудит хийлгэн, Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын чуулганы 6 дугаар сарын 23-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлгийг танилцуулсан. Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 2024 онд 29 их наяд 670,8 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр дүн зээлийн дүн 30 их наяд 591,1 тэрбум төгрөг, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 2 их наяд 451 тэрбум төгрөгөөр сайжирч 920,2 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан ба сүүлийн 3 жил дараалан төсвийн алдагдлыг үе шаттайгаар бууруулж ажиллалаа.

Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд тус Байнгын хороонд харьяалагдах Боловсролын сайд, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд, Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын харьяаны шинжлэх ухааны салбарын байгууллагууд нийт 2349 төсөвт байгууллага, 1 төсөл сан, төрийн өмчийн 20 аж ахуйн нэгж, нийт 2370 байгууллагын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг нэгтгэн гаргасан болно. Нэгдсэн төсвийн гүйцэтгэлээр тус Байнгын хорооны төсвийн ерөнхийлөн захирагчдын нийт зарлага болон цэвэр зээлийн дүн 4 их наяд 519,3 тэрбум төгрөгийн гүйцэтгэл гарч, урсгал зардалд 3 их наяд 790,3 тэрбум төгрөг, хөрөнгийн зардалд 727 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан байна. Нийт зарлага болон цэвэр зээлийн дүнгийн 87 хувь буюу 3 их наяд 947 тэрбум төгрөгийг Боловсролын сайд, 11,1 хувь буюу 501 тэрбум төгрөгийг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд, 1,6 хувь буюу 72,7 тэрбум төгрөгийг шинжлэх ухааны байгууллагуудын зарлага эзэлж байна. Улсын төсвөөс 4 их наяд 520,1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон бол төсөвт байгууллагын өөрийн орлогоор 5,2 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлсэн байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд тус Байнгын хороонд харьяалагдах 3 төсвийн ерөнхийлөн захирагчийн 585 төсөл, арга хэмжээнд 755,2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгож, гүйцэтгэл 76,4 хувийн биелэлттэй байна.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, та бүхэн 2024 онд төсвийн гүйцэтгэлийн үр дүнгийн тоон үзүүлэлтүүд болон бусад холбогдох тайлан, танилцуулга, аудитын дүгнэлтүүдтэй танилцаж, Төсвийн тухай хуулийн дагуу Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцүүлж өгнө үү. Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Рэгдэл: Жавхлан сайдад баярлалаа. Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 24 оны санхүүгийн нэгдсэн тайланд хийсэн аудитын тайланг Монгол Улсын Ерөнхий аудитор Сандагийн Магнайсүрэн танилцуулна.

С.Магнайсүрэн: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын тухай болон Төсвийн тухай хуульд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагчдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ. Тус Байнгын хороонд харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын талаар тоймлон танилцуулъя.

1.Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 1807 тайлан нэгтгэгдсэнээс 956 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 851 байгууллагыг түүвэрт хамрууллаа. Аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хязгаарлалттай, харьяа 885 байгууллагад өөрчлөлтгүй, 68 байгууллагад хязгаарлалттай, 2 байгууллагад сөрөг дүгнэлт өгч, 1 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөөс татгалзлаа. Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 409,6 тэрбум төгрөгийн зөрчил илэрснээс 2,2 тэрбум төгрөгийн зөрчилд 685 төлбөрийн акт, 235 тэрбум төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 918 албан шаардлага, 171,7 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1458 зөвлөмж өгч, 0,3 тэрбум төгрөгийн 18 зөрчилд хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлээд байна. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 121,8 тэрбум төгрөгийн алдаа илэрснээс 120,9 тэрбум төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 0,9 тэрбум төгрөгийн алдааг залруулах 61 зөвлөмжийг өгч ажиллалаа.

2.Соёл, спорт, аялал жуулчлал залуучуудын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 497 тайлан нэгтгэсэнээс 162 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 333 байгууллагыг аудитын түүвэрт хамруулсан бол Биеийн тамир, спортын улсын хорооны харьяа 2 байгууллага аудитад хамрагдаагүй байна. Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хязгаарлалттай, харьяа 136 байгууллагад өөрчлөлтгүй, 23 байгууллагад хязгаарлалттай, 2 байгууллагад сөрөг дүгнэлт өгч, 1 байгууллагын санхүүгийн тайланд аудит дүгнэлт өгөхөөс татгалзлаа. Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 36,4 тэрбум төгрөгийн зөрчил илэрснээс 1,4 тэрбум төгрөгийн зөрчилд 194 төлбөрийн акт тогтоож, 28,9 тэрбум төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 277 албан шаардлага, 5,9 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 363 зөвлөмж өгч, албан тушаалтанд хариуцлага тооцуулах 11 албан шаардлага хүргүүлж, 0,2 тэрбум төгрөгийн 5 асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэсэн ба нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 93,1 тэрбум төгрөгийн алдааг аудитын явцад залруулж ажилласан байна.

3.Шинжлэх ухааны академийн Ерөнхийлөгчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 17 тайлан нэгтгэгдсэнээс 6 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 11 байгууллагыг түүвэрт хамрууллаа. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгдсэн тайланд өөрчлөлтгүй, харьяа 5 байгууллагад өөрчлөлтгүй, Палеонтологийн хүрээлэнд хязгаарлалттай дүгнэлт өглөө. Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 0,4 тэрбум төгрөгийн зөрчил илэрснээс 0,01 тэрбум төгрөгийн зөрчилд 6 төлбөрийн акт тогтоож, 0,1 тэрбум төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 11 албан шаардлага, 0,3 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй 20 зөвлөмж өгсөн ба нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 0,8 тэрбум төгрөгийн 17 алдааг аудитын явцад залруулж ажиллалаа.

Дээр дурдсан аудитын дүн дүгнэлтээс үндэслэн дараах асуудлуудад анхаарал хандуулах шаардлагатай гэж үзэж байна, үзлээ. Үүнд, Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, хэрэгжилтэд тавьж буй захиалагч болон зохиогчийн хяналт дотоод аудитын нэгжийн үйл ажиллагааг сайжруулах. 2.Хэрэгжилт удааширсан болон олон жил дуусаагүй байгаа төсөл, арга хэмжээг богино хугацаанд үр ашигтайгаар дуусгаж, ашиглалтад оруулах шийдэл, зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх. 3.Төсвийн

ерөнхийлөн захирагчид худалдан авах ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулах. 4.Төсвийн ерөнхийлөн захирагч нар хуулиар олгосон бүрэн эрхийн хүрээнд зарим журам аргачлалыг батлан гаргаагүйгээс өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагаанд эрсдэл үүсгэсэн асуудлыг таслан зогсоох. 5.Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийг өмнөх онтой харьцуулахад Боловсролын сайд болон Соёл, спорт аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний зөрчлийн тоо нэмэгдсэн байгааг анхаарах. 6.Аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр үр дүнтэй арга хэмжээг зохион байгуулж, алдаа зөрчил гаргахгүй байх зэрэг болно. Танилцуулж дууслаа. Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Рэгдэл: Ерөнхий аудитор Магнайсүрэн танд их баярлалаа. Сангийн сайдын танилцуулга болон аудитын тайлантай холбогдуулан асуулт асуух гишүүн нэрээ өгнө үү? 2 тайлбар байна. 1 дүгээрт энэ асуудлыг хэлэлцэх хэлэлцээд, сонсоод Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асууна гэсэн ийм дэг байдаг юм байна 1 дүгээрт. 2 дугаарт асуулт асууж дуусаад, дараа нь үг хэлэх нь тусдаа явах юм байгаа юм. Тийм учраас асуулт асуух гишүүдийн нэрсийг авъя. Саранчулуун гишүүнээр тасаллаа. Саранчулуун гишүүний микрофоныг өгнө үү.

О.Саранчулуун: Их, дээд сургуулийн тогтмол зардлыг хасаж байгаа. Энэ нь өөрөө их, дээд сургуулийн багш нарын цалин эсвэл сургалтын төлбөр дээр нөлөөлж байгаа, сургалтын дотуур байран дээр бас нөлөөлж байгаа. Тэгэхээр энэ дээр ямар хувилбар байсан юм бэ, өөр арга байгаагүй юу гэдгийг дахиад нэг сайн тодруулаад өгөөч. Яагаад гэвэл их, дээд сургуулийнхнаас асуулт надад ирж байгаа. Тэгэхээр энэ дээр тайлбар сонсох хүсэлтэй байна.

Д.Рэгдэл: Боловсролын сайд Наранбаяр хариулах юм байна, микрофоныг нь өгөөрэй 4.

П.Наранбаяр: Саранчулуун гишүүний асуултад хариулъя. Баярлалаа. Энэ дараагийн тодотголын асуудал дээр уг нь ярилцах зүйл. Гэхдээ таны асуултад хариулахад энэ 13 тэрбум төгрөгийн тодотгол, 13 тэрбум төгрөгөөр төрийн өмчийн 7 сургууль дээр энэ тогтмол зардлыг нь өгөхөөр анх төсөвлөгдсөн ийм төсөв байсан. Энэ бол цахилгаан дулааных нь зардалд өгч, тухайн төрийн өмчийн сургуулиудыг нэлээн дэмжиж байгаа ийм хэлбэр байсан. Гэхдээ энэ удаагийн энэ төсөв өөрөө өнөөдөр хүндрээд ямар байдалтай байгааг энэ Сангийн сайдын илтгэл танилцуулгаас та бүхэн харж байгаа. Тэгээд энэ хүндэрсэн нөхцөл байдал дунд Улсын Их Хурлын тогтоолынх нь төслийг нь харахад төлбөрөө нэмэгдүүлэх замаар энэ асуудлаа шийдвэрлэ гэсэн ийм л байдалтай байгаа. Ер нь цаашдаа бид энэ төрийн өмчийнхөө сургуулиудыг ялангуяа энэ голлосон энэ 7 сургууль яг энэ сургуулиудаа судалгааны сургууль болгож, инновацын сургуулиуд болгож ингэж хөгжүүлэх л ийм бодлого барихын тулд төрөөс боломжтой үедээ байнга дэмжих ёстой. Энэ Дээд боловсролын тухай хууль дээрээ ч ийм заалттай байдаг ийм л зүйл. Гэхдээ энэ өнөөдрийн энэ эдийн засгийн түр зуурын хүндрэлээс болж байгаа асуудал л гэж харж байгаа. Ийм байна.

Д.Рэгдэл: Жавхлан сайд нэмж хариулна.

Б.Жавхлан: Гишүүний асуултад нэмж хариулъя. Нөгөө төсөв тэлээд байгаа хуулиар төсөв хуваарилаад байгаа шалтгаануудын нэг нь энэ. 9 сарын 1-нд зэрэг 40-өөд хууль бараг төсөвтэй цуг өргөн барих байх. Аль хэдийн төсөв хийхээс өмнө хуулиар ингээд салбар салбарт төсвийг данхайтал нь данхайтал нь хуваарилчихсан байж байдаг. Тэгээд төсөв данхайлаа гэдэг. Гэтэл хуулиар энэ чинь ерөөсөө ийм аргагүй болгоод хаячихсан байдаг. Тэгэхээр тэр ирэх намар орж ирэх хуулиуд дотор энэ хууль орж ирнэ, бүр хууль дээрээс нь хасна, тийм санал оруулж ирнэ. Маш олон салбар салбарын хуулиуд дээр ийм төсөв хуваарилчихсан зүйлүүдийг цэгцэлнэ. Тэгж байж төсөв хуулиар тэлээд байгааг зогсооно гэсэн үг. Төсвийн реформ эндээс л эхэлнэ. Зарлагын реформ эндээс л эхэлнэ. Энэ хуулийг, эдгээр хуулиудыг өөрчлөхгүйгээр бид ямар ч реформ хийх боломжгүй. Тийм учраас ийм өөрчлөлтүүд орж ирнэ, тэр үед бүгд нөгөө.../минут дуусав/

Д.Рэгдэл: Саранчулуун гишүүн тодотгож асууна, микрофон өгөөрэй.

О.Саранчулуун: Төсөв данхайгаад хасагдаж байгаа гэдгийг санааг нь бүх юмыг нь ойлгож байгаа. Нэг өрөөндөө их, дээд сургууль яадаг вэ гэхлээр нэг өрөөндөө доод тал нь 8-аас дээш хүн суугаад, тойроод нэг өрөөндөө суудаг ийм багш нар ажилладаг ийм байгууллага. Хуучин байшинтай ер нь төрийн өмчийн их, дээд сургууль ийм шүү дээ. Зарим дотуур байрны өрөө бол халаалт байхгүй байдаг, зарим анги танхим хэцүү байдаг ийм байгууллага байгаа ер нь. Тэгсэн ч гэсэн ингээд л нөгөө мэргэжилдээ хайртай дуртай болохлоороо хамгийн бага цалинтайдаа ч ордог, тэгээд ажлаа хийдэг ийм байгууллага төрийн өмчийн их, дээд сургууль бол. Монгол Улсад ажиллаж байгаа мэргэжилтнүүд ихэнх хүмүүс бага зардлаар хамгийн өндөр боловсролыг төрийн өмчийн их, дээд сургуулиасаа олж авдаг юм. Тэгэхлээр яах вэ би зүгээр юуг анхааруулаад одоо ярьж байгаа вэ гэхлээр ер нь тэр хууль руу нь ч гэсэн орох л юм байна. Тэгвэл 1 өрөөнд, 10 багш сууж байгаа 1 өрөөнд нэг дарга суудаг өрөөнийхөө зардлыг танаарай. Ер нь.../минут дуусав/

Д.Рэгдэл: Тодотгож асуусан уу, асуугаагүй юу, үг хэлсэн үү? Баярлалаа. Би нэг асуулт асуух байсан юм. Би тэгээд нэрээ өгч болдог юм уу, үгүй юу мэдэхгүй сууж байгаад асуучихъя. Энэ 24 оны гүйцэтгэлээс харахад ер нь төсвийн ерөнхийлөн захирагч нарт нэлээн хэмнэлт гардаг юм байна. Яах вэ Боловсролын сайдын хувьд төсвийн багц нь их том юм. Энэ чинь үндсэндээ 4 их наядаас дээш багцтай 3 сайдын нэг. Гэлээ ч гэсэн нэг 200 гаруй тэрбум төгрөг хэмнэгдээд үлдчихдэг учир шалтгаан юу байдаг юм бол 1 дүгээрт? 2 дугаарт би бас Соёл, спорт, залуучуудын сайдаас асуумаар байгаа юм. Бас л хэмнэлт 75 тэрбум төгрөгийн хэмнэлт гарч байгаа. Энэ төсвийн багцад нь аваад үзэхээр зэрэг эзэлж байгаа хувь хэмжээ нь нэлээн өндөр. Энэ юун дээрээ ингэж хэмнэлт гараад байдаг юм бэ? Би ямар утгаар асууж байна вэ гэхээр зэрэг ингээд хэмнээд байдаг юм бол илүү хэрэгцээтэй газар нь л уг нь төлөвлөөд л өгчихвөл зүгээр юм байгаа юм л даа. 2 сайд хариулах юм байна. Наранбаяр сайд микрофон 4.

П.Наранбаяр: Баярлалаа. Рэгдэл гишүүний асуултад хариулъя. Боловсролын сайдын багцын 24 оны төсвийн гүйцэтгэл 95,1 хувьтай байгаа. 204 тэрбум төгрөгийг санхүүжүүлээгүй. Үүнд нь бол ойролцоогоор цалин хөлс орсон, байр ашиглалт нь 91 сая байх жишээтэй. Бусад бараа, материалын зардал 23 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил 2,1 тэрбум гэх мэтээр ингээд урсгал шилжүүлэг нь 25 сая, 25 тэрбум эд нар гээд ийм санхүүжилтийн дутуу санхүүжилт байдаг. Тэгэхээрээ энэ дээр гол юмнууд нь ямар байдлаар энэ юу хэмнэлт гараад байдаг

вэ гэхээрээ төсөл, арга хэмжээнүүдийн санхүүжилтээ авч чадахгүй байгаа тохиолдол байдаг. Тэр нь нөгөө газар нь байхгүй, зураг нь байхгүй, төсөв нь байхгүй, зарлагчигдсан ажлууд он дамжсан гэдэг юм уу, техникийн нөхцөлд нь өөрчлөлт орсон, геологийн дүгнэлт нь зөрсөн гэх мэтийн ийм ажлууд байна. Улсын комисс авч чадаагүйгээс өмнөх онуудад санхүүжилтээ татуулсан гэх мэтийн ийм шалтгаан. Түүний зэрэгцээ энэ хөрөнгө оруулалт талаасаа гадна энэ хүүхдийн энэ хичээлийн ирцтэй холбоотойгоор, энэ цэцэрлэгийн ирцтэй холбоотойгоор хоолных нь зардал нь хэмнэгдсэн эд нар ийм тохиолдлууд гардаг. Энэ болохоороо та бүхэн мэдэж байгаа ханиад томуутай үед чөлөө авсантай холбоотой ийм зүйлүүд бий. Сургууль, цэцэрлэгүүд амраад эхлэхээр зэрэг нийслэлд яг цэцэрлэгийн дүүргэлт 70 хүрэхгүй хувь руу орж ирдэг ийм нөхцөл байдал байдаг. Баярлалаа.

Д.Рэгдэл: Ундрам сайдад микрофоныг нь өгөөрэй.

Ч.Ундрам: Рэгдэл гишүүний асуултад хариулъя. Манайх энэ Боловсролын яамтай ер нь нэлээн төстэй, ихэнх хэмнэлт гарсан зардал нь хөрөнгийн зардал байдаг. Тэгээд энд ялангуяа шинээр барилга байгууламж барих, их засвар хийх гэсэн энэ төсвүүд нь цаг хугацаандаа тендер зарлаж, сонгон шалгаруулалт хийж гэрээ байгуулаагүйгээс болоод, эсвэл ажил нь гацсан, удааширсан гэсэн ийм гол, гол шалтгааны улмаас ийм хэмнэгдсэн асуудал байгаа. Тэгэхээр бид нар цаашдаа ер нь төсөв бол өмнөх жилийн 11 сарын 15 гэхэд батлагдаж байгаа, тэгээд энэ тендер зарлах, сонгон шалгаруулалт явуулах ажлаа нэлээн хурдтай явуулахад анхаарах ёстой л гэсэн ийм үг байгаа.

Д.Рэгдэл: Баярлалаа. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Сангийн сайдын танилцуулга болон аудитын тайлантай холбогдуулан үг хэлэх гишүүн байна уу? Байхгүй юм байна. Гишүүд үг хэлж дууслаа гэх үү ер нь энэ дээр номоор нь хэлбэл үг хэлэх гишүүн байсангүй. Энэнийг нь уншихаар үг хэлж дууслаа л гэдэг юм байна лээ. Үг хэлж дууслаа. Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх БСШУС-ын байнгын хорооны санал, дүгнэлтийг Төсвийн зарлагын дэд хороонд Улсын Их Хурлын гишүүн Хэрлэн танилцуулна. Улсын Их Хурлын гишүүн Хэрлэн танилцуулна.

18.17 цаг

Хоёр.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/

Дараагийн асуудалдаа оръё. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хоёр дахь

хэлэлцүүлгийг эхэлье. Энэ хэлэлцүүлэгт ирсэн ажлын хэсгийн бүрэлдэхүүн, өөрчлөлт орчихсон байгаа бүрэлдэхүүнийг танилцуулчихъя. Бусад бүрэлдэхүүн нь хуучнаараа. Сангийн сайд Жавхлан, Сангийн яамны ТНБД Ганбат, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Тулга, Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Батмөнх, Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга Ичинноров, Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга Бат-Эрдэнэ, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Ганзориг, Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга Гантогтох, Сангийн яамны Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга Амарбаясгалан, Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн Энхманлай, Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн мэргэжилтэн Очиртогтох, Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн Төгөлдөр, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн мэргэжилтэн Анар, бусад бүрэлдэхүүн хуучнаараа байгаа. Хуулийн төслүүдийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Болдын Жавхлан хийнэ.

Б.Жавхлан: Баярлалаа. Байнгын хороон дарга, эрхэм гишүүд ээ,

Дэлхий дахинд үүсээд буй сорилт бэрхшээлийн Монгол Улсын эдийн засаг, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, мөн Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт орсонтой холбоотойгоор Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.2, 34.1.4 дэх заалтын дагуу Монгол Улсын 2025 оны төсвийн тодотголын төслийг боловсруулж, 2025 оны 6 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Эдийн засгийн сорилт хүндрэлийг даван туулахад төсвийн сахилга бат, үр ашигтай зарцуулалт онц чухал үүрэгтэй. Тиймээс хэмнэлтийн тодотголд бүх шатын төрийн байгууллагуудын тэвчиж болох зардлыг хэмнэх зарчмыг баримталлаа.

Энэ хүрээнд бүх шатын төрийн байгууллагуудын хойшлуулж болох зардал, бүх хөтөлбөр, арга хэмжээг зогсооно. Үүнд цомхон бүтээмжтэй төртэй байхын тулд төрийн албаны орон тоог 2026 оны хөгжлийн төлөвлөгөөнд нийцүүлэн 9 хувиар бууруулахаар тооцлоо. Мөн төсвийн байгууллагын тээвэр, шатахуун, дотоод албан томилолт, хичээл үйлдвэрлэлийн зардал, төрийн өндөр дээд айлчлал болон өндөр түвшний зочин төлөөлөгч хүлээн авахаас бусад гадаад албан томилолт, зочин төлөөлөгч хүлээн авах зардал, тавилга, эд хогшил худалдан авах, урсгал засвар хийх болон багаж техникийн зардал, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад олгодог татаасны зардал, байгууллагаас олгох нэг удаагийн болон бусад төрлийн тэтгэмж, урамшуулал, хөтөлбөр, арга хэмжээний зардал зэргийг хэмнэхээр тооцож, холбогдох өөрчлөлтийн тодотгол төсөлд дууслаа.

Энэ хүрээнд Боловсролын сайдын багцын төсвийг 2025 онд батлагдсан төсвөөс урсгал зардал 171 тэрбум төгрөгөөр, хөрөнгийн зардал 33,7 тэрбум төгрөгөөр, нийт 204,7 тэрбум төгрөгийг бууруулахаар төлөвлөсөн болно. Тус салбарын багцаас бусад төрийн албан хаагчийн тоог 9 хувиар буюу 3850 орон тоогоор бууруулж, 90,4 мянган орон тоотой байхаар тооцлоо. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын багцын төсөв 2025 оны батлагдсан төсвөөс урсгал зардал 66 тэрбум төгрөгөөр, хөрөнгийн зардал 19 тэрбум төгрөгөөр, нийт 86 тэрбум төгрөгөөр бууруулахаар төлөвлөсөн болно. Тус салбарын төрийн албан хаагчийн тоог 9 хувиар буюу 699 орон тоог бууруулж, 7,8 мянган орон тоотой байхаар тооцлоо. Ийнхүү 2025 оны төсөвт тодотгол хийснээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг 3 их наяд 260 тэрбум төгрөгөөр бууруулж, 30 их наяд 209 тэрбум төгрөг, нэгдсэн төсвийн нийт зарлагын хэмжээг 1 их наяд 856 тэрбум

төгрөгөөр бууруулж, 31 их наяд 575,1 тэрбум төгрөгт хүргэж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 1 их наяд 365,2 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 1,5 хувийн алдагдалтай болж байна.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон дагалдах хууль тогтоомжийн төслүүдийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Рэгдэл: Жавхлан сайд баярлалаа. Эдгээр хуулийн төсөлд хийсэн аудитын дүгнэлтийн талаар Монгол Улсын Ерөнхий аудитор Сандагийн Магнайсайхан танилцуулна.

С.Магнайсүрэн: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын байгууллага Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, Төрийн аудитын тухай хуульд заасныг тус тус үндэслэн Монгол Улсын ЗГ-аас 2025 оны 6 сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд дүгнэлт өгөх аудитыг хийж гүйцэтгэлээ. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тус Байнгын хороонд хамаарах 2 төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нийт 1 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, зарлагыг 291 тэрбум төгрөгөөр бууруулахаар төлөвлөсөн байна.

Байнгын хороо энэхүү төслийг хэлэлцэн шийдвэрлэхдээ дараах асуудалд анхаарал хандуулахыг санал болгож байна. Үүнд, төрийн албан хаагчдын тоог чиг үүргийн давхардал, ажлын байрны ачаалалд бүрэн шинжилгээ хийгээгүйгээр нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан бүх төсвийн ерөнхийлөн захирагч нарын орон тоог жигд 9 хувиар бууруулахаар тогтоосон нь төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлж болзошгүй. Иймд төсвийн ерөнхийлөн захирагчдад өөрийн хариуцсан салбартаа чиг үүргийн шинжилгээ, ажлын байрны бүтээмжийн үнэлгээ хийсний үндсэн дээр ажлын ачааллыг оновчтой хуваарилах зорилгоор харьяа байгууллагуудын орон тоонд зохицуулалт хийх боломж олгох асуудлыг судалж үзэх.

2-т нь төсвийн тодотголтой хамт Улсын Их Хуралд өргөн барьсан тогтоолын төсөлд 2025, 2026 оны төсвийн жилд өндөр насны тэтгэвэр тогтоолгох болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар чөлөөлөгдсөн орон тоонд нөхөн томилгоо хийхгүй байх, шинээр ажлын чиг үүрэг, албан тушаалын орон тоо бий болгохгүй байх, ажлын байрны ачааллыг нягтруулах зэргээр цалин хөлсний зардлыг хэмнэх гэж заасан. Энэ нь чиг үүргийн судалгаа хийсний үндсэн дээр ажлын ачааллыг нягтруулж, орон тоогоо зорилтот түвшин хүртэл нэгэнт бууруулсан байгууллагад сул орон тоонд нөхөн томилгоо хийхгүй байх нь тухайн байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулах, үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь сөргөөр нөлөөлж болзошгүй байгааг анхаарч үзэх.

3-д нь төсвийн ерөнхийлөн захирагч нарын харьяа сул орон тооноос бусад цомхотголд орж буй албан хаагчдад Төрийн албаны тухай хуульд заасны дагуу ажлаас чөлөөлөгдсөний нэг удаагийн тэтгэмжийн зардал шаардагдахаар байгааг энэ хуулийн төслийн хэлэлцүүлгийн явцад хамтад нь шийдвэрлэх гарц шийдлийг гаргах.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан, хангаж байна гэж дүгнэснээ үүгээр танилцуулж байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Рэгдэл: Ерөнхий аудитор Магнайсүрэн танд баярлалаа. Хуулийн төслүүдийн талаарх Сангийн сайдын танилцуулга болон аудитын дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Галбадрах гишүүнээр тасаллаа. Улсын Их Хурлын гишүүн Хосбаярын микрофоныг өгье.

Г.Хосбаяр: Та бүхэнд оройн мэнд хүргэе. Энэ Соёлын сайдын төсөв дээр Биеийн тамир, спортын улсын хорооны зардал 32 тэрбум төгрөгийг 6,5-аар бууруулаад 25,8 болгосон байна л даа. Тэгээд энэ дотор нь бидэнд ирж байгаа мэдээллээр энэ Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл доор 7 сарын 25-наас 27-нд зохион байгуулагдах Улаанбаатар Их дуулга тэмцээн гээд жүдо бөхийн дэлхийн тамирчдад онооны чансааны оноо олгох ийм тэмцээн болох ёстой. Энэ тэмцээний зардал буюу 1,5 тэрбум төгрөг нь 500 саяар буурчихсан гэж ийм мэдээлэл ирээд байна. Тэгэхээр энэ дээр зарчмын зөрүүтэй санал гаргаж, энийг хэвээр нь үлдээх боломж байгаа юу гэж асуух гэсэн юм? Энэ эртнээс төлөвлөгдчихсөн ийм тэмцээн байгаа. Дээр нь Монгол Улс маань хүүхэд, залуучууд маань сүүлийн үед энэ спортоор амжилт гаргаж байна. Дэлхийд нэр алдраа гаргаж байна. Дээр нь Монгол Улсад гадаадын тамирчид ирж, энэ дэлхийн чансааны оноо олгох тэмцээнд оролцох учраас энэ зардлыг бууруулахгүй байх ийм асуудлыг хөндөж байна.

Д.Рэгдэл: Хосбаяр гишүүний микрофоныг, тайлбар хэлэх юм байна. Микрофоныг нь өгөөдхөөрэй.

Г.Хосбаяр: Тэгэхээр Соёл, спорт, залуучуудын сайдаас асуучихъя.

Д.Рэгдэл: Тэр хүн хариулах уу спортын? 5 дугаар микрофоныг өгөөрэй.

Э.Билэгт: Биеийн тамир, спортын улсын хороо Билэгт байна. Энэ дотоодод зохиогдох олон улсын тэмцээн уралдааны зардал буюу Засгийн газрын тогтоолоор зохион байгуулагддаг 11 тэмцээн байгаа. Үүний төсвөөс Чингис хаан гранд олон улсын их дуулга тэмцээний зардлаас 541 сая 264700-гийн буурсан ийм дүн байгаа. Энэ маань өнгөрсөн оноос 11 сард саналаа өгөөд, ингээд Засгийн газрын тогтоолоор өнгөрсөн 4 сар, 5 сард Засгийн газрын тогтоолоор батлагдсан ийм тэмцээн байгаа.

Д.Рэгдэл: Тодруулах уу? Хосбаяр гишүүний микрофоныг өгөөрэй.

Г.Хосбаяр: Тэгэхээр одоо яг яана гэсэн үг вэ? Энэ тэмцээн маань аль хэдийн зарлагдаад 7 сарын 25-наас 27-нд болно гэчихсэн. Дэлхийн олон орны тамирчид ирэх юм шиг байна. Тэгэхээр энэ зардал мөнгө юм нь ингээд хасагдчихаар яах ёстой байдаг юм бол?

Д.Рэгдэл: 5 дугаар микрофоныг.

Э.Билэгт: Засгийн газрын тогтоол дээр 1,5 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр ингэж Засгийн газрын тогтоол батлагдсан байгаа. Одоогийн төсвийн тодотгол дээр явж байгаа дүнгээр 1 тэрбум төгрөгөөр ингэж тусгасан буюу 541 сая төгрөгөөр буурсан ийм нөхцөл байдалтай байгаа.

Д.Рэгдэл: Улсын Их Хурлын гишүүн Отгоншарын Батнайрамдал гишүүн жаахан хоцорч орж ирсэн, бас асуулт асуух юм байна. Нэрийг нь өгнө. Улсын Их Хурлын гишүүн Хэрлэн асуулт асууна. Хэрлэн гишүүний микрофон.

Б.Хэрлэн: Бүгдэд нь энэ оройн мэнд хүргэе. Тэгэхээр надад 2 асуулт байгаад байгаа юм. Ер нь энэ бол Сангийн сайдад хандаж асуух гээд байгаа юм. Тэгэхээр төрийн албан хаагчдын тоог 9 хувиар бууруулна гэж яриад байгаа. Тэгээд энэ нь ер нь үйлчилгээний салбарт ажиллаж байгаа төрийн албан хаагчид ялангуяа боловсрол, соёл, урлаг, спорт энэ салбарт ажиллаж байгаа албан хаагчдын яг яах аргагүй самбарын өмнө заагаад л хичээл заадаг багш нар, тайзан дээр гараад л дуулдаг уран сайханч, жүжигчид. Тэгэхээр энэ хүмүүсээс орон тоог нь хасна гээд тэгэхээр чинь энэ талын үйлчилгээг үзүүлэх энэ боломж нөхцөл нь ер нь ямар болох бол? Бүгдээс нь ингээд тэгшитгээд 9 хувь хасна гэдэг энэ үйлчилгээний салбарын хувьд арай өөр байдлаар энд хандах ийм боломж байх уу, үгүй юү гэж би 1 дүгээрт асуумаар байгаа юм? Тэгээд ер нь зүгээр төрийн албан хаагчдынхаа тоог цөөлж, төсвийн мөнгийг хэмнэнэ гэхээсээ илүүгээр урсгал зардал дотор чинь маш их том хувь хэмжээг эзэлж байгаа тэр бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр хураамж гэдэг хэсгээс хасаж болоогүй юм уу? Тэр чинь ерөнхийдөө нэг их том саван дотор баахан юунд яг мөнгө зарцуулагдах нь мэдэгдэхгүй маш их хэмжээний төсөв мөнгө дотор тэнд яваад байдаг. Тэрнээс жаахан хэмнэхивэл энэ нэг төрийн, ялангуяа энэ төрийн үйлчилгээний албан хаагч, төрийн албан хаагчдаас нэг их хасаж танаад байх шаардлага гарахгүй юм биш үү гэж би 1 дүгээрт асуумаар байна?

2 дугаарт нь энэ Дээд боловсролын тухай хуулийн 32.3-д заасан байгаа. Ер нь дээд боловсролын байгууллагад тэр нэг тогтмол зардлыг төрөөс дэмжлэг болгон үзүүлнэ гээд. Тэгээд энэнтэй нь уялдуулаад нөгөө нэг дөнгөж сая Саранчулуун гишүүн асуусан л даа. Энэнтэй нь уялдуулаад энэ зардлыг мөнгийг хэрвээ 13 тэрбум 500 мянган, 500 сая төгрөгийг ингээд олгохгүй гээд ингээд ороод ирчхэж. Энэ зардал мөнгө чинь эцсийн дүндээ их, дээд сургуулийн дотуур байрыг засахад, тэгээд их, дээд сургуулийн багш нарыг чадавхжуулахад зарцуулагддаг. Тэгэхээр яг үнэнийг хэлэхэд энэ мөнгө байхгүй болсноороо оюутан, сурагчдын сургалтын төлбөр нэмэгдээд явчихна. Дээд боловсролын сургуулийн багш нарыг цааш нь мэргэжил ахиулах, сургах, хөгжүүлэх энэ тухай ажлууд шууд тасалдаад явчихна л даа. Тэгэхээр энэ бүх юм бол яах аргагүй нөгөө ард иргэдийн сургалтын төлбөр төлж байгаа иргэдийн нуруун дээр л энэ бууна гэсэн үг. Тэгэхээр энийг ер нь бодолцох боломж байх уу гэж Сангийн сайдаас асуумаар байна?

Д.Рэгдэл: Жавхлан сайд хариулна, Жавхлан сайдын микрофон.

Б.Жавхлан: Хэрлэн гишүүний асуултад хариулъя. Засгийн газар тодотголоо Их Хуралд өргөн барьчихсан. Тэгэхээр тодотгол дотор уг нь нэлээн хасна, хасна гээд, танана гээд гишүүд маань нэлээн зоригтой байсан. Ороод ирсэн

чинь бүгдээрээ танахгүй, танахгүй гээд нөгөө тийшээ уралдаад эхэллээ. Тэгэхээр үнэхээр танамааргүй бол ажлын хэсэг гарчихсан ажиллаж байгаа. Тэгээд түүн дээрээ л саналаа яриад, тэгээд хураалгаад явсан нь зөв байх. Тийм.

Ер нь нэгэнт орлого тасарч байгаа ийм үед боломжтой танаж болох зардлуудаа ингээд эрэмбэлээд оруулж ирсэн байгаа юм. Зүгээр яах вэ би тодруулж хэлье. Хэрлэн гишүүнээ. Тэр 9 хувийг чинь тодотголоор хасах гээд байгаа зүйл ерөөсөө огт биш шүү. Энэ чинь төлөвлөгөө 2026 оны улсын төлөвлөгөөг Их Хурал баталчихсан шүү дээ сая 5 сард. Түүн дотроо 9 хувиар хасаарай гээд бүр Улсын Их Хурал баталчихсан. Тэгээд тэрийг ингээд хэрэгжүүлэхдээ 2026 онд нэг дор бол чадахгүй. Тийм учраас тодотголоор ингээд эхлүүлээд ядаж эхлээд сул орон тооноос нь шахаад явъя гэдгээр ингээд явж байгаа.

Бусдаар гүйцэтгүүлнэ гэдэг маань төр өөрийнхөө зарим чиг үүргийг хувийн хэвшлээр хийлгэж байгаа тэрний л төлбөр шүү дээ. Тэр нэлээдгүй 400 гаруй сая тэрбум төгрөгөөр мөн хасагдсан байгаа. Ингээд тэр 9 хувийг бууруулахаар энэ бусдаар гүйцэтгүүлэх ажлууд бас зөрөөд 2026 онд нэмэгдэнэ. Орон тоогоо хасчихаар тэр хэмжээний төрийн үйлчилгээг бусдаар хувийн хэвшлээр гүйцэтгүүлээд, түүн дээр нь төлбөр нь нэмэгдэж л таараа. Ийм л зүйлүүд байгаа шүү. Тогтмол зардал яах аргагүй эхний бүтэн жил тавигдаад, эхний хагас жилд огт зардал нь гараагүй ийм зардлуудыг нэг ижил зарчмаар бүх төсвийн ерөнхий захирагч нар дээр танагдахаар ингэж төсөлд өргөн баригдсан байгаа. Түүн дотор энэ зардлууд ороод явж байгаа тийм.

Д.Рэгдэл: Галбадрах гишүүн асуух юм байна.

Ж.Галбадрах: Та бүхэнд оройн мэнд хүргэе. Энэ жил төсвийн тодотгол ингээд жил дуусаагүй байхдаа орж ирж байна. Тэгээд энэ маань энэ орлого багассантай холбоотой. Тэгээд орлого багасахаар ер нь Сангийн сайдын хэлээд байгаачлан данхар төрийг хумих тийм боломж гэж ярьдаг. Гэхдээ бид данхар төрөө яаж хумих вэ? Ялангуяа манай энэ боловсролын салбар дээр энэ данхар төрийг гээд л боловсролын салбар дээрх жишээлбэл саяын яриад байгаа хүний нөөцийн цомхотголын энэ 9 хувь гэдэг ямар судалгаа дээр үндэслэж, ямар зарчим дээр явж байна вэ? Бид угаасаа багш, эмч нарыгаа цомхотгохгүй гэсэн байгаа. Тэгэхээр яг боловсролын салбар дээр ямар албан тушаалтан, ямар хүмүүсийг цомхотгох ийм зарчим барьж байгаа вэ, ямар судалгаа хийсэн бэ гэдгийг асууя?

Ирэх жил боловсролыг дэмжих жил гээд зарласан байгаа. Шинэ ЗГ, шинэ Ерөнхий сайд маань энийгээ дэмжээд, энэ бодлогоо бариад явна гэсэн. Энэ жил ингээд юу маань цомхотгож танагдаж байна. Энэтэй холбогдоод тэр боловсролыг дэмжих жилээ угтаад энэ тавигдсан ажлууд хэр хийгдэх ийм боломжууд байгаа вэ? Та нар маань энэ багшийн хомсдол гэхэд л илт нүүрлэхдээ байна. Саяхан бид нар энд хэлэлцүүлэг хийсэн. Багшийн хомсдол, өнөөгийн бодит байдал, тэгээд шийдвэрлэх замууд гээд судлаачдын, их, дээд сургуулийн багш бэлдэж байгаа хүмүүс, мөн сургууль, цэцэрлэгийн захирал, удирдлагуудын саналыг сонссон. Маш бодитой тийм судалгаатай тоонуудыг тэнд хэлсэн. Эсрэгээрээ бидэнд багшийг нэмэхийн тулд зайлшгүй урсгал засвар дээр нэмэх, багшийг дэмжих энэ асуудлууд яригдсан. Тэгэхээр энэ маань ингээд төсөв танагдсантай, тэгээд багшийн хомсдолыг хангах гэсэн энэ байдал дээр Боловсролын яам маань ямар уян хатан

бодлого барьж ингэж ажиллах зүйл хийсэн бэ? Боловсролын салбарт нийтдээ 204 тэрбум төгрөг танагдаж байгаа юм байна.

Мөн 3 яам Хяналт, үнэлгээний үндэсний хороо, Боомтын сэргэлтийн үндэсний хороо, 20 минутын хороо гэдгээс энэ төсвүүд хэмнэгдэж байгаа байх гэж бодож байгаа. Чиг үүрэг нь бусад яамдад очсон. Үүнтэй холбоотой ямар хэмнэлтүүд гарах вэ гэдгийг нэг асууя. Тэгээд Улсын Их Хурлын дарга Боловсролын ерөнхий хуулийг дэмжих ажлын хэсэг, Засгийн газар дээр ажлын хэсгүүд гараад судалгаанууд хийгдээд, бид нар ирэх жил 45 сургууль шинээр барих, 45 цэцэрлэг шинээр барих, гүйцээж барих, би бол боловсролын салбар дээр л яриад байна, ийм төлөвлөгөөнүүд байгаа. Энэ төлөвлөгөөнүүд хэр энэ төсөвт танагдсанаас болж сургуулийн тоо.../минут дуусав/

Д.Рэгдэл: Наранбаяр сайд хариулна, 4 дүгээр микрофон.

П.Наранбаяр: Энэ ер нь энэ төсвийн хүндрэл хаана хаанаа ийм хэцүү нөхцөл байдлыг авчирч байгааг та бүхэн өөрсдөө ойлгож байгаа. Энэ нийгмийн салбартаа ч гэсэн өнөөдөр ингээд ороод ирж байна. 105-аар тооцож байсан нүүрсний үнэ 70 доллар луу орж ирээд, төсөв өөрөө ингээд 3 их наяд давсан ийм тасралттай болох ийм магадлал өндөр болоод энэ ингээд тодотгол орж ирж байгаа гэж ойлгож байгаа. Гэлээ гээд ирэх жилийг Боловсролыг дэмжих жил хэвээрээ байлгана гэсэн. Дээр нь нэмээд хүний хөгжил бол мега төслийн нэг байх болно гэдгийг Монгол Улсын Ерөнхий сайд маш тодорхой чуулганы танхимд хэлсэн. Энэ хүрээндээ бид ингээд тооцоод үзэхэд ер нь 560 орчим тэрбум төгрөгийг энэ төсвийн хүрээний хязгаарт тавиулсан. Өөрөөр хэлбэл энэ хөрөнгө оруулалт талдаа. Энэ дээр нэмэх нь 2026 оны төсвийн хязгаарт 200 тэрбум төгрөгийг нэмж тусгах ийм боломжтой гэж. Ингэснээр энэ хүрээндээ ачаалал өндөртэй байршлуудын сургууль, цэцэрлэгийн барилгыг барих ийм боломжтой болж байгаа.

Түүнээс гадна багшаас бусад 46 мянган албан хаагчийн энийг 9 хувиар тооцож, багшаас бусад албан тушаалтны хувьд тодотголд туссан цалин, Нийгмийн даатгалын шимтгэлийн сангаас нийтдээ 55 тэрбум төгрөг буурахаар тооцож байгаа. Тэгэхээрээ бид уучлаарай сая яахад 563 тэрбум дотроо энэ 200 тэрбум нь шинээр барих барилга байшиндаа сургуульд оруулъя, 360-ыг нь шилжих төсөлдөө оруулъя гэсэн ийм нөхцөл байдалтай байгаа. Ер нь цаашдаа бид энэ гадаадаас орж ирэх Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк зэрэг Монголын боловсролд дорвитой хөрөнгө оруулалт оруулъя, энэ тэгш хүртээмжийг нэмэгдүүлэхэд сургуулийн, цэцэрлэгийн барилга байгууламжийг сайжруулахад, нэмэгдүүлэхэд хөнгөлөлттэй зээл гэх мэт хамтын ажиллагаагаа хийх ийм боломжтой гэж ярьж байгаа ийм байгууллагууд байгаа. Санхүүгийн ийм instrument-д ийм санхүүгийн байгууллагууд байгаа. Дэлхийн банк байна, Азийн хөгжлийн банк байна. Эдгээр улсуудтай ярилцаж, хөнгөлөлттэй зээл авах ийм зүйлүүдийг хийх ёстой гэж бодож байгаа. Энэ нэг ойролцоогоор 100-аас 150 сая долларын хэмжээнд боломжтой юм байна лээ. Гэхдээ энэ бол Сангийн яамтайгаа бид ярилцах ёстой. Нэгэнт төсөв ийм хүндэрсэн үед өрийн тааз нь энд нь таарах ёстой. Энэ ажлуудыг бид хийж бүрдүүлэх ёстой гэж ингэж харж байна.

Ингээд Ерөнхий сайдын энэ захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн дүгнэлтийг бид ерөнхийд нь гаргаад, 2030 он хүртэлх энэ 88 мянган хүүхдээр өсөх цэвэр өсөлт нь энэ дээр байгаа шүү дээ ерөнхий боловсрол дээр. Энэнийхээ энэ

хүүхдүүдийг сургууль, цэцэрлэгээр хэрхэн хангах, багшаар хэрхэн хангах, багшийн дутагдлыг хэрхэн арилгах гэдэг иж бүрэн бодлогоо бид боловсруулаад, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр өнөөдөр энэ бид Засгийн газрын хуралдааны товд оруулж байгаа. Энийгээ оруулж ирсний дараа иж бүрэн бодлогоо та бүхэнд танилцуулаад ингээд явах болно. Мөн яаралтай хийж байгаа ажлуудыг өнөөдөр нийслэл дээр 33 байрлал дээр газар чөлөөлөх ажлыг нийслэлийн төсөвт суулгасан байна. 45 сургууль, цэцэрлэгийг шинээр барихын 33-ыг нь газар нь чөлөөлөгдөж байгаа төсөвт нь тусаж байгаа. Ийм мэдээ байгаа. Баярлалаа.

Д.Рэгдэл: Галбадрах гишүүн тодруулах юм байна. Хариулт нэмж Эдийн засаг, хөгжлийн яамнаас хариу өгөх юм байна. Микрофон хэдэд байна вэ? 5 дугаар микрофон, цаг чинь явж байна шүү.

И.Батхүү: Эдийн засаг, хөгжлийн яамны ТНБД Батхүү. Гишүүний асуултад хариулъя. Энэ төрийн албан хаагчдын 9 хувиар орон тоог бууруулах гэдэг асуудал улсын хөгжлийн жилийн 2026 оны төлөвлөгөөнд тусгагдсан зорилт байгаа. Энэ зорилтыг хэрэгжүүлэхийн тулд ер нь төрийн албаны чиг үүргийн шинжилгээ хийх, төрийн бүтээмжийг дээшлүүлэх, цахимжуулах гэх мэтчилэн бүх төрлийн арга хэмжээг авч хэрэгжүүлээд, хамгийн оновчтой байдлаар тухайн алба, төрийн байгууллагын онцлогт нь тохируулсан байдлаар ялгаатай байдлаар хэрэгжүүлэх ёстой гэж төлөвлөж, 2026 онд хэрэгжүүлэхээр тусгаж байсан. Засгийн газрын тодотгол хийхтэй холбоотой хэмнэлтийн төсвийн тодотголтой холбоотой энэ 9 хувьтай ойролцоо дүнгээр ингэж цомхотгол хийх арга хэмжээг боловсруулж оруулж ирсэн байгаа. Яг манай Эдийн засаг, хөгжлийн яамнаас боловсруулсан улсын хөгжлийн жилийн.../минут дуусав/

Д.Рэгдэл: Нэмж хариулах уу? 5 дугаар микрофоныг өгөөрэй.

И.Батхүү: Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд яг ямар үг үсгээр суусан бэ гэдгийг уншиж танилцуулъя. 4.4.1.1 дээр төрийн албаны цахим системийг хиймэл оюун технологийн дэвшилд суурилан хөгжүүлж, цахим шилжилтийг эрчимжүүлэх, 4.5.1.1 дээр төрийн үйлчилгээнд процессын дахин инженерчлэл хийх ажлыг үе шаттай хэрэгжүүлэх гэдэг төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үндсэн зорилго нь төрийн албаны реформ хийх гэдэг агуулга дээр. Төрийн албаны шинэчлэлийг хийж, чиг үүргийн давхардлыг арилгаж, төрийн албан хаагчдын тоог үүнд багш, эмч нараас бусад 9 хувиар бууруулах замаар чадварлаг, цомхон, бүтээмжид суурилсан, төрийн албыг бэхжүүлнэ гэсэн ийм зорилт реформ хийе гэсэн тусгасан байгаа.

Д.Рэгдэл: Галбадрах гишүүн тодруулна, Галбадрах гишүүн.

Ж.Галбадрах: Тэгээд манай Боловсролын яам, Сангийн яамныхан маань уг нь ингээд цуг суугаад ажлын хэсэг дээрээ яваад байгаа. Тэгээд энд сая бид нар гүйцэтгэл дээр ингээд харахад 231 тэрбум төгрөг хэмнэгдлээ. Түүн дотор барилга байгууламжийнхаа бэлтгэлийг сайн хангаагүй, зураг дутуу байсан, газар нь зөвшөөрөл нь гараагүй, техникийн нөхцөл нь олгогдоогүй байсан гэдэг ийм юмнаас болоод ийм 0 хувийн гүйцэтгэлтэй энэ барилга байгууламж гараад байна. Тэгэхээр энийг ийм зүйл гаргахгүй байх тал дээр цаашид их сайн анхаарах хэрэгтэй. Тэрийгээ нийслэлтэйгээ бүүр сайн ярьж байгаад ингээд бид дандаа л жил болгон нэг ийм хэмнэлт гэдэг юм уу, буцаалт гэдэг юм уу, хөрөнгө оруулалтаа авч чадаагүй гэдэг энэ зүйл дээр цаашид их нэлээн сайн анхаарах хэрэгтэй байна

гэдгийг хэлмээр байна. Тэгээд миний гол хэлээд байгаа зүйл энэ цомхотгол дээр тэр үйлчилгээний ажилтнууд дээр л бүгдээрээ их сайн зарчим бодлого барихгүй бол.../минут дуусав/

Д.Рэгдэл: Цаг авах уу? Галбадрах гишүүний микрофоныг дахиад 1 минут.

Ж.Галбадрах: Жишээлбэл нэг сургууль байхад 2 байртай, 2 өргөтгөлтэй дотуур байртай ч гэдэг юм уу гэхэд жижүүр жишээ нь нэг байна гээд ийм журамтай. Тэгээд тэр жижүүр чинь хаанаа хүрэх вэ? Тэгээд энэ бүгдийгээ ингээд тооцсон тэр энэ бол журмаа шинэчилчих ёстой. Тэгээд энэ журам дээрээ тохирсон энэ юмнуудаа бодлогоо ингэж сайн барихгүй бол тэр ялангуяа энэ салбарынхаа онцлогийг тооцоод, цомхотгол дээр нэлээн сайн анхаарах хэрэгтэй. Тэрнээс гадна бид бүхний анхаарах юм нь тэр түрүүн хэлсэн Азийн хөгжлийн банк ч юм уу, гаднын энэ эх үүсвэрийг, хөрөнгө оруулалтын эх үүсвэрүүдийг нэлээн сайн татах, тэгээд эртнээс энэ яриа хэлэлцээрээ сайн хийгээд яг зураг бүх зүйлээ гаргавал, би уулзалтад нь орж байсан, нэлээн хамтарч ажиллах ийм боломжууд их байгаа юм байна лээ. Энэ нөөц бололцоогоо сайн ашиглахыг хүсэж байна. Баярлалаа.

Д.Рэгдэл: Улсын Их Хурлын гишүүн Батнайрамдал асууна.

О.Батнайрамдал: Оройн мэнд хүргэе. Боловсролын сайдаас асуулт байна. 2024 оны төсвөөр бид нар Боловсролын зээлийн сан дээр түүхэн хэмжээнд төсөв баталсан 158,4 тэрбум төгрөгийг баталсан. Ямар ч байсан энэ төсвийн тодотголоор тэр 158,4 тэрбум 158,3 буюу нэг ёсондоо 0,07 хувийн л өөрчлөлт орсон юм байна. Боловсролын зээлийн сангаасаа таналт хийгдээгүй юм байна. Энийг албан ёсоор би энийг сонсож байгаа бүх эцэг, эх нарт хэлмээр байна. Боловсролын яамнаас Наранбаяр сайдаас, Сийлэгмаа даргаас боловсролын зээлийн сангаар тэтгэлэг авахад зээл авахад явж чадаагүй, яагаад гэвэл төсвийн тодотгол орсон учраас гэдэг тайлбар эндээс хойш байхгүй шүү.

Яагаад гэвэл төсвийн тодотголоор ЗГ-аас эндээс ерөөсөө хасалт хийгдээгүй байна. Нэг зүйлийг хэлье. 158,4 тэрбум төгрөг төсөвлөхөд 33,6 тэрбум нь эргэн төлөлтөөс хийгдэх ёстой байсан. Энэ эргэн төлөлт яг хэд хийгдсэн бэ? Хэд одоо хүртэл хийгдээгүй байна вэ? Энэ эргэн төлөлт хийгдэхгүй энэ ажлаас болоод яг хэдэн хүүхэд магистр, доктор, бакалаврт сурах боломжоо алдах вэ? Энийг би та яг тоотой нь хэлээсэй гэж бодож байна. Энэ эргэн төлөлт бол Боловсролын яамны яг 100 хувийн ажил. Энийг их анхааралтай яриад байгаа юм сайдаа. Яагаад гэвэл гомдол гаргаж явж байгаа хүүхэд болгоны ард насаараа хөдөлмөрлөсөн аав, ээж насаараа хуримтлалаа хүүхдийнхээ боловсролын төлөө бүхнээ зориулсан байдаг байхгүй юу. Нэг хүүхдийн гомдлын ард бүхэл бүтэн айлын насаараа хөдөлмөрлөсөн хөдөлмөрийнх нь хөлс нь явж байдаг. 1 дэлхийн топ сургуульд тэнцэх гэж тэр хүүхэд насаараа хөдөлмөрлөсөн, ямар их золиос гаргаж хөдөлмөрлөсөн байдаг билээ. Тийм болохоор энийг гомдлыг ерөөсөө Боловсролын зээлийн сан дээр гарч байгаа гомдлыг хүүхдийн тоогоор хэзээ ч авч үзэж болохгүй юм.

Яг энэ цаг мөчдөө яг таарч байна л даа. Боловсролын зээлийн сангийн шалгаруулалт явсан, өнөө маргаашгүй дүнгээ асууна. Дүнгээ асуух гэж байгаа хүүхэд болгон над руу холбогдоостой, миний инстаграмаар бичиж байна, фэйсбүүкээр бичиж байна. Хариу нь гараагүй байна гэж байна. Яасан юм бол, бөөн зовсон аав, ээж нар. 26 жил энэ боловсролын зээлийн сангийн журам

өөрчлөгдөж явахгүй, өөрчлөгдөж гэж дандаа нэг жоохон косметик засвар орж явсаар байгаад дөнгөж саяхан боловсролын яг энд сууж байгаа боловсролын, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны эрхэм гишүүд санал хурааж, энэ боловсрол Байнгын хорооны тогтоолыг баталж явуулсан. Бид хаврын чуулган эхлэнгүүт хоёрхон долоо хоногийн дотор өдөр, шөнөгүй хуралдаж байгаад энэ тогтоолыг явуулж байсан. Тэгээд яамнаас гарахдаа энэ цаг алдаж явсаар байгаад 4, 5 сард гараад, тэрнээс болоод олон хүүхэд хохирсон. Яагаад гэвэл явж чадаагүй, сургуульдаа хариу өгөх цаг нь хугацаа нь өнгөрчихсөн гээд.

Д.Рэгдэл: Батнайрамдал гишүүний микрофоныг.

О.Батнайрамдал: Тэр хүүхэд болгон над руу хандсан. Нэг ёсондоо бүгдээрээ боловсролын боломжоо, нэг ёсондоо энэ журам нь 2 сар болж хойшилсоор байтал, батлагдсаар байтал, хугацаа алдсаар байтал нөгөө сургуулийн хариу нь дууссан. Тэгээд энэ шинэ журмаараа боловсролын зээлийн сан гэж сонгон шалгаруулалт явсан. Бид Байнгын хорооны тогтоол дээр зарчмаа маш ойлгомжтой бичиж өгсөн. Тэгээд журам гарчихлаа. Журмыг огт бид батлагдтал нь бидэнд өгөөгүй харуулаагүй. Тэгээд сонгон шалгаруулалт явсан чинь бүрдүүлбэр гээд дэлхий дээр байхгүй юм асуусан. Энэ дээр маш их гомдол надад ирсэн. Тухайн сургуульд тэнцлээ, жишээлбэл Харвардын их сургуульд тэнцлээ. Тэгвэл тэр Харвардын их сургуулийнхаа портал руу ороод тэр сургуулийнхаа ордог тэр username паспорт эрхээ бүгдийг нь өгөхгүй бол.../минут дуусав/

Д.Рэгдэл: Наранбаяр сайд хариулах уу? 4 дүгээр микрофон.

П.Наранбаяр: Энэ асуултад хариулъя. Тэгээд нэмж хариулах бол Сийлэгмаа дарга хариулаарай. Энэ жил 33,6 тэрбум төгрөгийг өөрсдөө эргэн төлөлтөөр олж ав гэсэн ийм 24 оны төсвийн төсвийг хэлэлцэж, 25 оны төсвийг батлах үед ийм юм орж ирсэн. Энэ дээр нийтдээ 14 мянган иргэний мэдээллийг гадаад, дотоодод суралцсан хамаагүй Монголбанкны мэдээллийн сан руу шилжүүлсэн юм. Энэ ажил ерөөсөө явдаггүй байсан шүү дээ энэ явсан. Ингэснээрээ эргэн төлөлт эрс сайжирсныг би энэ микрофоныг ашиглаад хэлье. Хагас жилийн байдлаар 8 тэрбум төгрөг эргэн төлөгдсөн байна яг одоогийн байдлаар. Юуны хувьд бид төсөв хүрэлцэхгүйдээ хүүхдийг яаж байгаа юм биш, энэ чинь жил жилдээ квотоо гаргадаг. Гэхдээ энэ жилийн тухайд жишээлбэл 264 өргөдөл ирсэн байна. Тэгээд энэ жил бид энэ журмаа өөрчлөөд, та бүхний Улсын Их Хурлын тогтоолын дагуу журмаа өөрчлөөд, хүнээс үл хамаарах ийм дүн гаргадаг энэ хүнээс үл хамаарах энэ процессыг нэлээн сайжруулсан гэж харж байгаа. Урьд нь 80 хувь нь хүүхдүүдийн өөрсдийнх нь цуглуулсан оноо, тэгээд 20 хувь дээр нь хүүхдүүдээс янз бүрийн шалгалт авдаг байсан, шалгуулагчаас гэсэн үг, хүсэлт гаргасан хүмүүсээс. Энэ чинь 18 нас хүрчихсэн учраас хүүхэд гэж хэлэх нь ч хаашаа юм.

Тэгээд ингээд ийм нөхцөл байдалд байсныг бид 100 хувь тийм шалгалтгүй болгоод, яг зөвхөн материал дээр нь ажилладаг ийм байдлаар өөрчилсөн. Мөн тусгай аппликэйшн, тусгай программ хангамжаар хүсэлтээ өгчихсөн хүн өргөдлийнх нь маягтууд, бичиг баримтынх нь бүрдүүлбэрүүд ямар түвшинтэй явж байгааг өөрөө гар утсаараа хянах боломжтой болгочихсон. Ийм нөхцөл байдалтай явж эхэлсэн. Тэгээд ер нь зүгээр би, бид хөндлөнгөөс нь оролцох ямар ч эрхгүй учраас мэдээлэл ерөнхий мэдээллийг асууж үзэхэд бүх шаардлагын дагуу бүх

баримт бичгээ журамд заасан хугацааныхаа дагуу дуусгасан. Ажлын 2 хоногийн дотор зарлах ёстой, тэр нь маргааш юм байна лээ, ингээд зарлана.

Гэхдээ энэ дээр ингээд харахад үндсэн баримт материалуудын бүрдэл дутуугаар л хүн их хасагдаж байна лээ. Үндсэн ангидаа ороогүй ч юм уу, тийм байгаа бол тэгж хасагдсан тохиолдлууд гарсан байна лээ. Тэр хохироогоод байгаа юм бол байхгүй, бүх юмных нь ар талд тайлбар нь байгаа. Журмын аль, аль заалтуудыг зөрчсөн бэ гээд. Та мэдэж байгаа бүх хүн тэнцлээ гээд ирэхэд шалгах ёстой, тэр таны шүүмжлээд байгаа зүйлийг харин тантай ярьж байгаад бид энийг яаж хүнээс үл хамаарч болох вэ гэдгийг бодох ёстой. Тэр их, дээд сургуулиас нь ирүүлсэн баримт бичгүүдийг нягталж харах шаардлага гардаг. Ийм тохиолдолд нууцыг хамгаалах үүрэг хүлээсэн ийм ажилтан нь өөрөө тэр хүнтэйгээ ярилцаад аваад, 2 хоногийн дараа буцааж тэрийг нь өөрөөр нь хаалгасан ийм л юмнууд байгаа юм лээ. Нарийвчилсан юмыг нь Сийлэгмаа дарга тайлбарлана биз. Тэгэхгүйгээр яаж тэгвэл тэрийг зөвхөн pdf-р хүлээж аваад ингээд явахаар баримт бичиг хуурамчаар үйлдсэн тохиолдлууд гарч байсан гэдгийг хэлье.

Тэгээд энэ жилийн тухайд бид ийм байдлаар бид энэ хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэгээд магистр, докторт суралцах иргэд, бакалаврт суралцах ийм иргэдийн ийм материалуудыг нь эцсийн байдлаар хянаж шалгаад ингээд зарлахад бэлэн болсон байгаа гэдгийг хэлье. Тэгээд энд ямар нэгэн хөндлөнгийн оролцоо байхгүй, яг хүнээс үл хамаарах байдлаар ажлын хэсэг нь өөрсдөө ажиллаад, материалуудыг бүрэн шалгаж ингэж дуусаж байгаа гэдгийг танд хэлье. Баярлалаа.

Д.Рэгдэл: Нэмж хариулах уу? Тодруулга 5 дугаар микрофон.

О.Сийлэгмаа: Бүгдэд нь өдрийн мэнд. Гишүүний асуултад хариулъя. Саяын хэлсэнчлэн 156 тэрбум төгрөгийн 33,6 тэрбум нь зээлийн сангийн эргэн төлөлт болон бусад эх үүсвэр байгаа. Саяын хэлсэнчлэн Засгийн газрын тэтгэлгээр энэ 33,6 тэрбум төгрөгөөр нийтдээ 4654 оюутан суралцагчийг 33,6 тэрбум төгрөгийг цуглуулж байж суралцуулах буюу санхүүжүүлэх эх үүсвэртэй. Үүнээс 1,2 тэрбум төгрөг нь Засгийн газрын тэтгэлэгт 50 суралцагчийн асуудал байгаа. Гэхдээ 25 оны сонгон шалгаруулалтад нийтдээ 55 иргэн ахисан түвшинд суралцахаар бичиг баримтын хүсэлт ирүүлсэн байсан. Үүнээс бичиг баримтын шаардлага хангаагүй буюу элсэлтийн захиагаа урилга болгож баталгаажуулаагүй, нэхэмжлэл ирүүлээгүй, зөрөөтэй бичиг баримт ирсэн ийм асуудлаар нийтдээ одоогийн байдлаар 35 оюутны иргэнийг материалын шаардлага хангаагүй гээд бүрдэлд тайлбар өгчихсөн байж байгаа. Албан ёсоор журмын 3.12-т заасны дагуу 2 дугаар улиралд сонгон шалгаруулалтыг зарлаж.../минут дуусав/

Д.Рэгдэл: Батнайрамдал гишүүн тодруулах уу? Батнайрамдал гишүүний микрофон.

О.Батнайрамдал: Энэ дээр нэг нэмж тодруулах юм байна. Тэр 8 тэрбум төгрөг 2025 оны 1 сарын 1-нээс хойш мөнгө үү, 8 тэрбум, тэгээд Монголбанканд тэр мэдүүлэг. Тэгэхээр 33,6-аас 8 нь, тэгвэл үлдсэн 24 орчим тэрбум төгрөг эргэн төлөгдөхөд ямар төлөвлөгөө байгаа вэ? Энэ дээр яаж ажиллана гэж бодож байгаа юм бэ? Монголбанк руу тэр мэдээлэл өглөө гээд асуудал шийдэгдсэн гэж ерөөсөө үзэхгүй байна. Яагаад гэвэл эндээс дутаж байгаа доллар болгон, төгрөг болгон нэг хүүхдийн боломж, боловсролын боломж салхинд хийсэж байна гэсэн үг байхгүй юу 1 дүгээрт.

2 дугаарт та сая яг тоогоор хэлж байна л даа. Өргөдлийн бүрдүүлбэр дээр бүгдээрээ бүдэрч байна л гэсэн асуулт, хариулт хэлж байгаа байхгүй юу. Хар даа нэг зүйлийг ойлгох хэрэгтэй. Азийн сургууль, Америкийн сургууль эд нар чинь бүгдээрээ ондоо, ондоо зүйл, ондоо, ондоо нюанстай юмнууд байгаа юм. Тэр болгоныг нь энэ чинь манай журмаар ингээд ерөөсөө нэг ёсондоо манай журам нь өөрөө тэр болгоныг нь авч үзэж чадахгүйгээсээ болоод тэр хүүхэд ингээд хохирч байгаа маш олон хүүхдүүд над дээр ирээд ирээд байна шүү дээ. Тэгэхээр өргөдлийн бүрдүүлбэр гэдэг чинь журмаас гадна та нарыг хүнд.../минут дуусав/

Д.Рэгдэл: Наранбаяр сайд 4 дүгээр микрофон. Баярлалаа.

П.Наранбаяр: Тэгэхээр тэр эргэн төлөлт нь нэг сараас хойш ингээд төлөгдөж байгаа 8 тэрбумд ороод ирчихсэн. Цаашаагаа энэ эрчээрээ явбал нэлээн хэмжээнд төлөгдчих болов уу гэж харж байна. Түүний зэрэгцээ бид энэ хуулийн фермүүдтэй ярилцаж, сонгон шалгаруулалт хийж, энэ хуулийн хүрээнд эргэн төлүүлэх энэ ажлыг эрчимжүүлэхээр ингэж явж байгаа. Тэгэхээр энэ ажлууд ингээд эхэлбэл бид энэ 33,6 тэрбум гэсэн үүргээ биелүүлчих байх гэж ингэж харж байгаа. Ер нь тэтгэлгээ эргэн төлж байна л гэдэг чинь өөрөө тэтгэлэг олгогч болж хувирч байгаа гэдгийг хүмүүс их сайн ухамсарлах хэрэгтэй. Төлөөд, төрөөр төлүүлээд өөрөө өндөр боловсрол эзэмшчихсэн бол бусдадаа боломжоо олгоё гэдэг ийм хандлага энэ нийгэмд өөрөө энэ ноёлоод эхэлбэл болно. Ингэж л бид харж байгаа юм. Энэ бол өөрөө эерэг соёлыг бий болгож байгаа сайн зүйл гэж харж байгаа шүү. 2 дахь асуултын тухайд манай Сийлэгмаа дарга хариулна.

Д.Рэгдэл: Эрдэнэбат гишүүн асууна.

С.Эрдэнэбат: Боловсрол, эрүүл мэнд гэхээр багш, эмч байдаг, өөр хүмүүс нэг их байдаггүй гэж ерөөсөө үзэж болохгүй л дээ. Хөгжлийн төлөвлөгөө дээр эрүүл мэнд, багш, эмчээс бусад гэдэг байдлаар хэлсэн гээд бусдыг нь хасаж танана гээд. Бидний хүүхдүүдийг хүргэж өгөхөд өглөө тосож авдаг, хоолыг нь хийж өгдөг хүмүүс хүртэл ордог. Тийм учраас энэ тал дээр би энэ боловсрол, эрүүл мэндийн салбараас хүмүүс цомхотгохгүй, төсвийг нь хасахгүй гэж ойлгож байсан бас нэлээдгүй юм ороод ирлээ. Энэ гүйцэтгэлийн үнэлгээ дээр 87 тэрбум ерөнхий боловсрол, сургуулийн өмнөх боловсрол 36 тэрбум гээд, 100 гаруй тэрбум төгрөг гээд нөгөө гүйцэтгэлийн үнэлгээний хүрч ядаж байгаа бөөн хэл амтай байгаа юман дээр нь дахиад хасаж байгаа юм байна л даа. Энэ асуудлыг ингэхгүй байж болоогүй юм байх даа гэж 1 дүгээрт хэлмээр байна.

2 дугаарт их, дээд сургуулиудын, төрийн өмчийн их, дээд сургуулиудын төрийн өмчийн байгууллага тодорхой хэмжээний татаас буюу ашиглалтын зардлыг нь олгоод, үүгээр нь жишээлбэл тэр багш нарынхаа цалин хөлсийг нэмж, боловсон хүчнээ тогтоон барих бодлогоо хий, оюутнуудын сургалтын төлбөрийг айхтар их битгий нэм гэдэг ийм зохицуулалт хийсэн юм л даа. Тэгээд юу төсвөөс харахаар бараг 13 тэрбум төгрөг энэ жил тавигдсан, тэр чигээрээ хасагдах ийм юм руу ороод ирчихсэн. Тэгээд 1 сараас хойш энэ 6 сар хүртэл энэ ашиглалтынхаа зардлыг өгч байгаагүй юм уу, өгч байгаагүй учраас шууд тэр чигээрээ хасагдаад байна. Энийг тодорхой хэмжээнд нь үлдээх хийх ийм боломж бололцоо байна уу гэдэг ийм асуултыг асуумаар байна?

Д.Рэгдэл: Жавхлан сайд.

Б.Жавхлан: Эдийн засгийн хөгжлийн яам тэр 9 хувьтай холбоотой асуултдаа хариулаарай. Би бусад ерөнхий тандалт хийсэн зарчим дээр би хэлье. Ингээд л ёстой салбар салбарын ийм хамгаалагч гарч ирээд энэ зардлуудаа танахгүй гэвэл тодотгол хийх ямар ч боломж байхгүй. 2026 оны төсвийг өргөн барихад ч ингээд салбар салбараа хамгаалаад, зардлуудаа ингээд дэлбэ, дэлбэ тавиад явбал бас л хэцүү болно. 26 оны төсөв өргөн барихад би дахиад хэлье 40 гаруй хууль өргөн барина. Түүн дотор боловсролын энэ хуулиуд орно. Боловсролын багц хуулийн шинэчлэл гээд, боловсролын салбарын шинэчлэл гээд ер нь агуулгын шинэчлэл гэхээсээ илүү энэ төсвийг л дахиад хуваарилчихсан юм хуулиудаараа. Маш их төсөв хуваарилсан боловсролын салбарт. Эдгээрийг эрэмбэлж байгаад хасах, хуулиас нь хасуулах, эрэмбэлэх ийм асуудлуудыг 9 сард өргөн барина. Тэр үед одоо энэ тоогоор хасагдаж байгаа бол хуулиар нь хасах тийм саналууд оруулж ирнэ. Харин энэ дээр нөгөө төсөв танаж байна гэж их шүүмжилдэг гишүүд маань л эргэлт буцалтгүй дэмжинэ гэдэгт би ерөөсөө огт эргэлзэхгүй байгаа. Ингэж байж бид нар төсвийн шинэчлэлийг хийнэ шүү гэдгийг дахин хэлье.

Д.Рэгдэл: 5 дугаар микрофоныг өгөөрэй.

И.Батхүү: Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя. Түрүүн дурдсан улсын хөгжлийн 2026 оны жилийн төлөвлөгөө бол Улсын Их Хурлаар батлагдсан эрх зүйн хүчин төгөлдөр баримт бичиг байгаа. Энэ баримт бичиг дээр төрийн албаны реформыг хийхдээ төрийн албаны шинэчлэлийг хийж, чиг үүргийн давхардлыг арилгаж, төрийн албан хаагчдын тоог 9 хувиар бууруулах замаар гээд чадварлаг, цомхон, бүтээмжид суурилсан төрийн албаны тогтолцоог бэхжүүлэх тийм зорилгыг зааж өгсөн байгаа. Зүгээр цомхотгохдоо хөдөлмөрийн зах зээл дээр хамгийн их дутагдалтай байгаа эмч, багш нар гэдэг энэ 2 мэргэжлийг тодотгож өгсөн байгаа. Ер нь бол энэнээс бусдыг нь шууд автоматаар хас гэсэн үг биш. Арга замыг нь зааж өгсөн. Гэхдээ хэрэгжүүлэхдээ тухайн төрийн алба, байгууллагын онцлог, ажил үүргийн, чиг үүргийн ачаалал, онцлогийн бүрэн шинжилгээ хийж байж, 2026 оноос хэрэгжүүл гэсэн бодлогын тэргүүлэх чиглэл төрийн албаны реформ байгаа. Энэ дээр яг тэр албанаас нь төдийг хас гэсэн тодорхой тоо байхгүй байгаа.

Д.Рэгдэл: Наранбаяр сайд 4 дүгээр микрофон.

П.Наранбаяр: Гүйцэтгэлийн үнэлгээний тухайд яг энэ бол тэндээсээ буурна гэж ороогүй, хувьсах зардлаас нь бууруулахаар туссан байгаа шүү. Ер нь гүйцэтгэлийн үнэлгээний ач холбогдлыг бид үнэлдэг. Энэ бол яг цөм хөтөлбөр, сургалтынхаа хөтөлбөрийг илүү сайн гүйцэтгэх, багшийн чадварыг дээшлүүлэх, илүү сэтгэлтэй ажиллахад энэ их эерэг нөлөө үзүүлдэг ийм зүйл байгаа. Нөгөө талдаа энэ Дээд боловсролын тухай хуульд гүйцэтгэлээр нь санхүүжүүлэхээр заасан байдаг учраас энэ хагас жилээр нь 5,8 тэрбум олгохоор байсан нь ингээд тодотголоор байхгүй болж байгаа. Тэр саяын нөгөө нэг тогтмол зардал нь. Тэгээд ингээд нийтдээ нэг энэ тодотгол ингээд энэ 2 нийлээд 13 орчим тэрбум төгрөг рүү орж байгаа юм. Ийм байдалтай байгаа.

Д.Рэгдэл: Эрдэнэбат гишүүн тодруулна.

С.Эрдэнэбат: Боловсрол, эрүүл мэндийн салбар дээр ямар чиг үүрэг давхцаад байгаа гэдгийг тэр энэ 5 номер дээр байж байгаа чинь хаанахын Эдийн засгийн хөгжлийн яам билүү? Энэ боловсрол, эрүүл мэндийн байгууллагаар яваад үзээрэй. Тэртээ тэргүй багш нар дутуу байгаа, тэртээ тэргүй сувилагч нар дутуу байгаа, тэртээ тэргүй үйлчилгээний ажилчид дутуу байгаа юман дээр чиг үүрэг давхцаж байна гээд 9 хувиар нь шууд танана гэдэг чинь өөрөө эргээд энэ хүмүүсийг чинь олж авах гэж нэлээн асуудал болж байсан. Энэний өмнө нэг үйлчилгээний ажилчдыг хувийн хэвшил рүү гаргачихъя гэж байгаад эргээд олж авах гэж хүүхдүүдэд хоол хийх тогооч олдохгүй иймэрхүү байдалтай хүртэл болчихсон байгаа шүү яг бодит байдал. Тийм учраас энийгээ хийхдээ учиртай тавиарай. Үг үсгээр хөөцөлдөх бол яах вэ. Хөгжлийн төлөвлөгөө дээр байж байгаа зөндөө зүйлийг хэрэгжсэнгүй гээд л ингээд хаядаг урсгалаар. Яг энийг л зөвхөн барина гээд яваад байвал энийг би өөр салбар энэ дээр уян хатан байгаарай гэдгийг хэлмээр байна. Тэгээд их, дээд сургуулийн юун дээр тийм юман дээр бодоорой. Намар ирэхэд баахан оюутнуудын төлбөр нэмнэ гээд бөөн асуудал болчихсон байж байх вий.

Д.Рэгдэл: Үг хэллээ. Би 2 асуулт асууна. 1 дүгээрт энэ ЮНЕСКО-ын экспертүүд Монголд ирээд танай шинжлэх ухааны салбарын хамгийн эмзэг хэсэг бол санхүүжилтийн ганцхан эх үүсвэртэй юм гэж 2 удаа зөвлөгөө өгөөд, тэгээд тэр ганц эх үүсвэр бол Шинжлэх ухаан, технологийн сан байгаа юм. Одоо үндэсний гэдэг тодотголтой болчихсон. Тэр сан энэ 25 он гараад энэ үндсэн үйл ажиллагаа нь эрдэм шинжилгээний зардал, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн үндсэн чиглэлийн санхүүжилт гээд нэг ч төгрөгийн санхүүжилт хийсэнгүй тэр сангаас хагас жил өнгөрлөө. Тэр сан одоо ер нь байдаг юм уу, байдаггүй юм уу? Тэр талаар нэг тодорхой хариулт өгөөч. Ер нь миний бодлоор энэ шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогыг Эдийн засгийн хөгжлийн яаман дээр өгсөн нь их зөв гэж бодож явдаг хүн. Гэтэл нөгөө сахил хүртээд шал дордов гэгчээр бүтэн жил эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд санхүүжилт авалгүй хагас жил өнгөрлөө 1 дүгээрт.

2 дугаар асуулт бол энэ тэр эрдэм шинжилгээний зардал гээд байгаа Үндэсний шинжлэх ухаан, технологийн сан дээр байгаа тэр зардал үндсэндээ яах вэ сүүлийн 10 жилийн дунджаар 10 тэрбум төгрөг. Энэ 25 онд 12,1 тэрбумаар баталсан. Гэтэл энэ зардлаар чинь тэр эрдэм шинжилгээний ажилтнууд эрдэм шинжилгээний ажилдаа хэрэгтэй эм урвалж худалдаж авдаг, жижиг сажиг хэрэгсэл, багаж хэрэгслээ авдаг, хөдөө экспедицээр явдаг ийм юм байгаа юм. Гэтэл энэ төсвийн тодотголоор 45 хувийг нь хэмнээд хасаад хаячхаж байгаа юм. Энэ чинь ямар нэгэн төсөл, хөтөлбөр дутуу байна, хэрэгжээгүй байна, 6 сарын 31-нээс өмнө гэрээгээ хийгээгүй байна гэдгээс чинь шал өөр юм шүү дээ. Энэ чинь тэр системийг ажиллуулж байдаг бензин нь байгаад байдаг. Тэгэхээр энэнийг ерөөсөө хасаж болохгүй гэж би бодож байгаа. Тэгэхээр энэнийг залруулах ямар боломж байна вэ? Энэ 2 дугаар асуудал байна. Үүнд нэг тодорхой, тодорхой товчхон шиг хариу өгөөч?

Түүнээс ер нь дахиад 3 дахь асуулт, 3 дахь асуултаа. Бүх хүнээ 9 хувь төрийн албаныхаа 9 хувиар хэмнэнэ гэж байгаа юм. Тэгэхээр манай Монгол Улсын эрдэм шинжилгээний ажилтнуудыг ЮНЕСКО-оос хэлэхдээ та нар ер нь Азийн дундаж түвшинд очиж байж танайх хэвийн эрдэм шинжилгээний ажилтны тоо чинь хангагдана. Манайх бол 1 сая хүнд ноогдох эрдэм шинжилгээний ажилтны тоогоороо Азийн дунджаас 3 дахин доогуур. Тэр Финлянд гээд Европын өндөр хөгжилтэй орнуудтай харьцуулахад 20 дахин доогуур. Энэ салбарт орон тоог

сүүлийн 20 жилд ганцхан удаа орон тоо жаахан нэмсэн тэр нь 95 хүнээр нэмсэн. Одоо дахиад 9 хувиар хасна гэхээр зэрэг чинь 1400 хүн хасах гэж байгаа юм. Бид аль болохоор орон тоогоо нэмэлгүй яваад л энэ салбар чинь байсан чинь тэндээс нэг эрдэм шинжилгээний ажилтан хэдэн хүн хасах гээд ингээд байдаг нь ямар учиртай юм? Энэ чинь багш, эмч нараас үнэ цэн багатай улсууд биш шүү дээ. Энэ ТЗ энэ тэр арай өөрөөр хандаж болдог. Энэ ийм 3 асуултад нэг сайн хариулаад өгнө үү? 5 дугаар микрофон. Эдийн засаг, хөгжлийн яам хариулах юм байна.

Д.Баттогтох: Эдийн засаг, хөгжлийн яам Шинжлэх ухааны нэгдсэн бодлогын газрын дарга Баттогтох. Гишүүний асуултад хариулъя. 2024 оны тухайд эрдэм шинжилгээний зардал манай Шинжлэх ухаан, технологийн сан буюу тусгай сан дээр 11,3 тэрбум төгрөг батлагдсан байдаг. Тэгээд үүнтэй холбоотойгоор үргэлжилж байгаа төсөлд нийтдээ 2,5 тэрбум төгрөг. Шинээр хэрэгжиж байгаа төсөл дээр үндсэндээ 5,3 тэрбум төгрөгийг төсөвлөж, хөтөлбөр арга хэмжээний тушаал гарсан. Тэгэхээр үүнтэй холбогдолтой үргэлжилж байгаа төслүүд өмнө нь тушаал гарчихсан, гэрээ нь хийгдсэн төслүүд учраас шууд шилжээд явах бололцоотой. Тэгэхээр энэ чиглэлийг яамнаас санал өгсөн байгаа. Тэгээд үүнээс гадна шинээр хэрэгжүүлж байгаа төсөлд гол нь үндсэн чиглэлийн санхүүжилт байгаа. Өөрөөр хэлбэл төрийн өмчит эрдэм шинжилгээний хүрээлэн судалгааныхаа үндсэн чиглэлээр санхүүжилт авдаг. Энэнтэй холбогдолтой ажлын хэсэг гараад өмнөх ажлыг үнэлээд, холбогдох сайдын тушаал мөн 32 хүрээлэн дээр гарч сан руу хүргүүлсэн байгаа. Тэгэхээр холбогдох тушаалуудын хүрээнд сан бол санхүүжилтийг Сангийн яамтай тохироод хийх ийм үүрэгтэй.

Тодотголын тухайд шинжлэх ухааны байгууллагын тухайд нийт төсөв 9 хувиар танагдаж байгаа. Гэхдээ таны дурдсан эрдэм шинжилгээний зардал энэ олон улсдаа судалгаа хөгжүүлэлтийн зардал гэж ярьдаг. Тэгэхээр энэ зардал нэг эх үүсвэр буюу ШУТС-гаас санхүүжиж байгаа. Энэ нийтдээ 11,3 тэрбумаас 48 хувиар танагдаад 5,9 тэрбум руу орж байгаа. Энэ зардал бол, энэ зардлаас бусад зардал нь нийтдээ 9 хувиар танагдаж байгаа. Тэгэхдээ тодотголын дараах зардлаар үргэлжилж байгаа төсөл болоод үндсэн чиглэлийн санхүүжилт тэгээд тодорхой хэмжээнд бага хэмжээнд шинэ төслүүдийг санхүүжүүлэх л ийм боломжууд үүсэж байгаа.

Эрдэм шинжилгээний ажилтны тоог бол та дурдчихлаа. Олон улсын дунджаас үндсэндээ 2-оос 3, хөгжингүй орнуудын эрдэм шинжилгээний байгууллагуудын ажилтнуудтай харьцуулахад нэлээн хол зөрөөтэй тоо байдаг даа. Үндсэндээ full time searcher гэж ярьдаг. Бүтэн цагаар ажилладаг эрдэм шинжилгээний 1300 орчим байгаа. Тэгэхээр энэ тооноос дахиад хасахад нэлээн л хүндрэлтэй байдал руу орно гэж харж байгаа.

Д.Рэгдэл: Сангийн сайд нэмж хариулах уу? Энэ тодотголоор яагаад энэ 45, Баттогтох дарга нь 48 хувь гээд яах юм. Надад өгсөн энэ тоог харвал 45 хувийн хэмнэлт хийгээд хаячихсан эрдэм шинжилгээний зардлаас. Энэ чинь тэр системийг ажиллуулдаг бензин болохоос биш, худалдан авалтаар өгөөд, хэрэгжүүлээгүй төслийн зардлаас шал өөр зардал шүү дээ. Тэгээд Баттогтох дарга тодорхой хариу өгсөнгүй. Ер нь танай яамны, би тодотгочихъё, дахиад жаахан тодотгочихъё. Тэгээд энэ үндэсний ШУТС хагас жил эрдэм шинжилгээний нэг ч байгууллагад нэг ч төгрөгийн санхүүжилт хийгээгүй байхад танай яам яагаад арга хэмжээ авдаггүй юм бэ? Тэгээд одоо энэ байгууллагуудаас энэ жил ямар үр дүн шаардах эрх байна вэ та нарт? Энэ чинь болохгүй шүү дээ, үр дүн, ямар ч үр дүн

гаргах байхгүй. Хөдөө экспедицээр явдаг ажлууд өнгөрчихсөн, ургамлын ... үе нь хоцорчихсон. Тэгээд ямар ч үр дүн шаардах эрхгүй яам яах юм бэ энийгээ? Энэ чинь тун харамсалтай юм байна шүү дээ. 6 дугаар микрофон, Ганбат дарга.

Ж.Ганбат: Асуултад нэмж хариулъя. Бид эхний 5 сарын гүйцэтгэлийг нэгэнт санхүүжилт нь гарчихсан учраас 6-аас 12 сар дээр үлдсэн санхүүжилтийг бүх газар дээр адил зарчим барьсан. Энэ дээр яах вэ бидний гол үндэслэл бол мэдээж төсвийн орлого 3,3 их наядаар буурч байгаатай холбогдуулан бүх байгууллагууд дээр хэмнэж болох зардлуудыг ерөнхийд нь бууруулсан. Яг энэ хүрээндээ л буурч байгаа. Энэ дээр дүнгүүд нь яг тоогоороо зарим дээр ялгаатай юм шиг харагдаад байгаа боловч энэ нь эхний 5 сард зарим байгууллагууд энэ зардлууд нь зарцуулагдаагүй, хэмнэлттэй явж байсан учраас яг хувиар бол адил хувиараа бууруулж байгаа. Зүгээр яах вэ тооны хувьд зарцуулагдаагүй үлдэгдэл их байсан учраас түүгээрээ өндөр дүнтэй харагдаж байгаа ийм юмнууд байгаа. Ер нь яах вэ энэ сангийн менежментийг сайжруулах шаардлага байгаа. Энэ тал.../минут дуусав/

Д.Рэгдэл: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71.5 дахь хэсэгт бусад Байнгын хороо Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанд гишүүн, нам, эвслийн бүлэг, төрийн аудитын төв байгууллага саналаа зарчмын зөрүүтэй саналын томьёоллын хамт гаргана гэж заасан байдаг. Зарчмын зөрүүтэй саналын томьёолол ирсэн. Тийм учраас гишүүд санал хураахад бэлтгээрэй. Зарчмын зөрүүтэй 3 санал ирсэн, 4 санал. 4 санал байгаа юм байна.

1 дүгээр санал. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн 35.3.1 дэх хэсгийн 35.3.1.1 дэх шалгуур үзүүлэлтийн “аялал жуулчлалын салбарын хүний нөөцийг чадавхжуулах сургалтад хамрагдах хүний тоо 100 мянга” гэснийг “15 мянга” гэж өөрчлөх. Санал гаргасан Соёл, спорт аялал жуулчлал, залуучуудын сайд, Улсын Их Хурлын гишүүн Чинбатын Ундрэм. Ундрэм гишүүн энэ санал дээрээ тайлбар өгье.

Ч.Ундрэм: Энэ Төсвийн тухай хуулийг дагалдаж орж байгаа 1 дүгээр хавсралтад манай яамны зорилтот түвшин байгаад байгаа юм. Тэгээд бид 2022 онд 10 мянган хүн сургалтад хамруулж байсан юм. Тэгээд тэгсэн чинь энэ жил 100 мянган хүн болоод ингээд гэнэт ийм том өөрчлөлт оруулаад батлуулчихсан байсан юм. Тэгээд манай энэ аялал жуулчлалын салбар чинь ер нь 88 мянган хүн энэ салбарт ажилладаг байхгүй юу. Гэтэл бүүр тэрнээсээ давсан 100 мянган хүн сургана гээд ингээд ороод ирсэн. Тэгэхээр энийг яг бодитой зөв болгох үүднээс бид нар 15 мянган хүн гээд өмнөх оныхоо зорилтот түвшнээс 5 мянган хүн нэмээд ингээд оруулж ирж байгаа юм. Тэгэхээр энийг гишүүд минь дэмжиж өгөөч.

Д.Рэгдэл: Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааа. Гишүүд саналаа өгөөрэй. 69,2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Дараагийн саналын томьёолол. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний 35.3.2 дахь хэсгийн 35.3.2.1 дэх шалгуур үзүүлэлтийн аялал жуулчлалын салбарын өрсөлдөх чадварын үзүүлэлт /индекс/-ийг “78” гэснийг 2025 онд хасах. Саналын тайлбар

өгөх үү, Ундрам гишүүн тайлбар өгөх үү энэ дээр, санал дээр? Тийм шаардлагагүй юм байна. Санал хураалт. 69,2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3 дахь санал. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын хөтөлбөрийн үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлтийг 2025 онд хүрэх зорилт түвшнийг “30 хувь” болгох гэж байна. Санал хураалт. 69,2 саналаар санал дэмжигдлээ.

Энийг чи уншаад байхаач, би уншиж чадахгүй юм байна энэ чинь. Хуулийн 12 дахь хэсгийн 1.1.168 дахь төсөл, арга хэмжээний дүнгээс “541000264,7” төгрөгөөр бууруулаад, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын Биеийн тамир, спортын улсын хорооны дотоодод зохиогдох олон улсын тэмцээний зардалд “541000264,7” төгрөгөөр зардлыг нэмэгдүүлэх гэсэн ийм зарчмын зөрүүтэй санал Эрдэнэбат гишүүн, Ганбаатар гишүүн гаргасан байна. Ганбаатар гишүүн тайлбарлах уу? Ганбаатар гишүүний микрофоныг.

А.Ганбаатар: Оройн мэнд хүргэе. Энэ нөгөө түрүүний Хосбаяр гишүүний хөндөөд байсан асуудал л даа. Жүдо бөхийн Их дуулга тэмцээн чинь нөгөө олон жил тогтмол ингээд яваад хэвшчихсэн олон улсын тэмцээн Монголд болж байгаа. Өөрөөр хэлбэл Монгол Улсыг гадаадад сурталчлаад байгаа нэг ийм тэмцээн байгаад байгаа юм. Энэ тэмцээнээс нь зардлаас 541 сая төгрөг л дутчихаад байгаа байхгүй юу хасчихсан. Тэгээд тэрийгээ нэмээд л Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд, Биеийн тамир, спортын улсын хорооны зардлаас нэмээд, түрүүний Рэгдэл гуайн эхэнд нь хэлдгээс бууруулчхаж байгаа юм. Тэгээд энэ төсөв нь 541 сая юм байгаа юм. Цаад ач холбогдол нь болохоор өмнө нь олон жил яваад сурчихсан олон улсынхан ингээд хараад сурчихсан тэмцээнээс хасах нь хэр зохимжтой юм болоо гээд. Тэгээд ерөнхийдөө бид нар сая өнгөрсөн хугацаанд харсан. Сагсан бөмбөгийн тэмцээн олон улс, дэлхийд Монголоо сурталчилж байна. Спортыг хэдүүлээ энтертайнмент шоу гэж харахаасаа илүү шинжлэх ухаан, дипломат, зөөлөн дипломатын арга хэрэгсэл юм гэж харвал энэ арга хэмжээнүүдээс л танахаас илүү нэмэх тал руу нь явах ёстой. Тэгэхээр энэ тогтчихсон арга хэмжээний зардлыг нэмж өгөөч гэж байгаа юм. 541 саяар, ингээд эрхэм гишүүд маань дэмжиж өгөхийг хүсэж байна.

Д.Рэгдэл: Жавхлан сайд тайлбар өгье гэж байна. Жавхлан сайдын микрофоныг.

Б.Жавхлан: Ганбаатар гишүүний саналыг хүндэтгэж байна. Гэхдээ би зүгээр энэ нэг юм сануулах гэсэн юм. Тэр барилга байгууламж, тэр спортын арга хэмжээний агуулга дээр нь хэлэх юм алга. Энэ Төсвийн хууль дээр ийм заалт байдаг юм шүү 29.3.6 дээр тухайн жилд батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг төсвийн тодотголоор бууруулахгүй гээд. Тэгэхээр энэ хууль зөрчигдөнө. Тэгээд энэ чинь уг нь тэр спортын арга хэмжээний чинь зардал чинь урсгал зардал байхгүй юу. Уг нь урсгалаас урсгал руу байвал зүгээр. Тэгэхгүй ингээд нөгөө хөрөнгө оруулалтаас хасаад, урсгал дээр тавих гэж байгаа чинь ингээд болохгүй болчхож байгаа юм, энэ хууль зөрчинө шүү.

Д.Рэгдэл: Тэгэхээр энэ яг Төсвийн тухай хуулиараа хууль зөрчих нь байна шүү дээ бид санал хураах юм бол. Ганбаатар гишүүн нэмэлт тайлбар өгье гэж байна.

А.Ганбаатар: Жавхлан сайд яах вэ хууль яриад явчихлаа л даа. Тэгвэл наадхаа татаад тэр хуульд нь нийцүүлснээр оруулчихъя л даа. Эсвэл сайдын багц, сайд өөрөө зохицуулчих ийм хэмжээнд хэрвээ тохирчихвол болно. Тэрнийг бол болох нь болно гэж хэлээд би оруулж байгаа шүү дээ санал зөрүүтэй. Ажлын хэсгээс асуугаад болох уу гэж хэлээд орсон шүү дээ. Санал хураачихвал яадаг юм бэ Рэгдэл гуай.

Д.Рэгдэл: Хууль зөрчих юм шиг л байна.

А.Ганбаатар: Ямар хууль хаана байгаа юм бэ, тэгээд харъя л даа.

Д.Рэгдэл: Тэгэхээр гишүүн тайлбараа өглөө. Тэгэхдээ зэрэг.../үг тасрав/

А.Ганбаатар: Үгүй ээ тэр зөрчөөд байгаа хуулиа дэлгэцээрээ харуулчих л даа. Хууль зөрчинө гэдгээ ямар хууль, яаж зөрчсөн юм тэгээд?

Д.Рэгдэл: Тэгвэл саналаа хураачихъя, санал хураачихъя. Санал хураалт. 53,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Бас 1 санал орж ирсэн байна. Санал гаргасан гишүүн Хэрлэн гишүүн гаргаж байна уу? Эрдэнэбат гишүүн, Хэрлэн гишүүн нар гаргаж байгаа юм байна. Харин тийм л дээ. Тэгэхдээ зүйл, заалтын дугаар байхгүй юман дээр энэ дээр чинь танилцуулах боломж алга байна шүү дээ. Ямар зүйл, заалтын ямар арга хэмжээний зардлаас нь, энэ бол санал хурааж болохгүй байх энэ чинь ямар ч зүйл, заалт заагаагүй юм чинь. Эрдэнэбат гишүүн нэг тайлбарлаадахгүй юу.

С.Эрдэнэбат: Түрүүний хэлсэн тэр бүтэн хагас жилийн турш их, дээд сургуулиуд гэрээ байгуулаад төсвөөс ашиглалтын зардал бусад тэр юугаа авна гэдэг байдлаар үүргээ гүйцэтгээд хийгээд бүх ажлаа төлөвлөчихсөн байгаа. Тийм учраас тэр 13,5 тэрбум төгрөгийн хасагдаж байгаагаас нь би тэр Боловсролын сайдынх нь багц дотор тэр бараа, үйлчилгээний зардал буюу 3 их наяд орчим төгрөг байгаа. Энэ дотроо зохицуулалт хийх байдлаар эндээс нь 5,8-ыг хасаад, нөгөө талд нь тэр төрийн өмчийн их, дээд сургуулиудын тэр урсгал зардлынх нь ядаж хагас жилийнх нь юмыг өг гэдэг ийм зарчмын санал оруулж байна. Тэгэхээр энэ дээр нөгөө зүйл, заалт гэхээр энэ өөрийнхөө хүснэгт дээр угаасаа зүйл, заалт алга энэ дээр. Би тоо тавих гээд, өгсөн материалд нь урд талд нь зүйл, заалт байхгүй учраас хүснэгт 1-ийн.../үг тасрав/

Д.Рэгдэл: Наадах чинь нөгөө зузаан дотор бол байж байгаа шүү дээ. Зузааны хавсралтад. Ерөнхийдөө ойлголоо. Тэгэхээр зэрэг яах вэ би, нэгэнт эндээс тайлбар хийчихлээ. Наранбаяр сайд энэ дээр тайлбар өгч болох уу?

П.Наранбаяр: Баярлалаа. Энэ бараа, үйлчилгээнийх нь зардлаас нь 5,8-ыг хасаад, тийш нь өгье гэсэн юм байсан уу, үгүй, юу гэсэн юм бэ? Энэ чинь бүүр шүүсийг нь шахаад, урсгал зардлаас нь 170 тэрбум төгрөгийг хасаад, хөрөнгө оруулалт төсөл, арга хэмжээнээс нь 33 аравны хэд билээ 6 тэрбумыг нь хасаад, ингээд бүүр бараг 204 тэрбум төгрөг болгоод оруулаад ирчихсэн ийм төсөв байгаа. Тэгээд энэнээс илүү хасаж, энэ дотор нь ингээд хөдөлгөнө гэвэл зүгээр ерөнхий боловсролын сургуулиуд, цэцэрлэгийн хэвийн үйл ажиллагааг хангах боломжгүй болж эхэлнэ. Хоолных нь зардлыг хүртэл хасаад хаячихсан шүү дээ түрүүнд яасан. Энэнээс илүү би энд, тэнд нь хөдөлгөж үнэхээрийн чадахгүй шүү.

Тэгээд яг үнэнийг хэлэхэд тэр юунууд нь жагсана уу, барина уу хэцүү байна. Ойлго л доо. Төсвөө хасуулж байгаа сайд шиг ийм хэцүү юм байхгүй байна шүү дээ. Миний биеийн нэг хэсгээс л тастаж байгаа юм шиг л ийм л мэдрэмж төрж байна шүү дээ. Тэгэхэд тэр дотор нь дахиж ингэнэ гэвэл бүүр хэцүү байдал үүснэ.

Д.Рэгдэл: Санал гаргагч гишүүн, салбарын төсвийн ерөнхийлөн захирагч сайд нарын саналыг манай гишүүд сонслоо. Тэгэхээр санал хураалгах уу? Боловсролын сайдын багцын бараа, үйлчилгээний зардлаас 5,8 тэрбум төгрөгийг хасаж, төрийн өмчит боловсролын байгууллагад татаас хэлбэрээр олгоё гэж. Төрийн өмчит их сургуулиудад гэсэн үг гэж би ойлгож байгаа. Микрофонд хэлчих. Хэрлэн гишүүн нэг тайлбар өгөх юм байна.

Б.Хэрлэн: Уучлаарай, энд бидэнд өгсөн энэ дэлгэрэнгүй мэдээлэл, бас энэ хураангуйлсан энэ мэдээлэл дотор яг нөгөө их, дээд сургуулийн үйл ажиллагаанд дэмжлэг төрөөс үзүүлж, тогтмол зардлыг 13 тэрбум 500 сая төгрөгийг олгох тухай асуудал яг энэ дээр бичигдээгүй байгаа. Тэгсэн хэр нь танай Боловсролын яамны ерөнхий санхүүч дээр тэр тоо бол яг ингээд байж байгаа байхгүй юу. Тэгэхээр сая хэлж байна л даа. Яг ямар зүйл, заалтад, ямар зарчмын зөрүүтэй санал оруулах гээд байгаа юм бэ гэхээр тоог нь ингээд бид эшлэл хийгээд тавихад 1 дүгээрт төвөгтэй болчихоод байна.

2 дугаарт энэ дээрээс юу хэлэх гээд байгаа юм бэ гэхээр энэ бол их, дээд сургуулийн багш нарыг эрдэм шинжилгээний ажилтнуудын мэргэжлийг дээшлүүлэх, их, дээд сургуулиудын дотуур байрыг засаж тохижуулах тухай асуудал бол яах аргагүй Наранбаяр сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах зүйлүүд. Тэрэнд чинь зориулсан мөнгийг танайд хамгийн их өндөр байгаа тэр бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний зардал дотроос урсгал зардлынхаа аль нэгээс нь аваад энийг зохицуулаад хийчхэж болохгүй юм уу? Дээд сургуулийн багш нар чинь өнөөдөр мэргэжил дээшлүүлэхгүй бол өнөөдөр их, дээд сургуульд чинь багшлах хүн байхгүй, бараг гаднаас багш нар авчирч хичээлийг нь заалгая гээд яриад явж байна шүү дээ. Тэгэхээр өөрөө өөрсдөө байгаа боломжоо, мөнгө төгрөгөө нэг зөв зохицуулаад, энэ хэдэн хүний мэргэжлийг дээшлүүлчих тухай дээр, дотуур байраа засах тухай дээр бодож болохгүй юм уу сайдаа?

Д.Рэгдэл: 4 дүгээр микрофон.

П.Наранбаяр: Өөр гарц байна уу? Энэ өөр гарц?

Д.Рэгдэл: Микрофон асчихсан.

П.Наранбаяр: Цалин руу орох гээд байна. Цалин руу орох гээд байгаа юм байна. Тэгэхээр бидний энэ урсгал зардлын 80 хувь нь цалин байгаа. Тэгээд энэ бол бүр юу ч үгүй шахаад ингээд яачихсан ийм төсөв. Сангийн яамтай бид ярилцаж энэ төсвийг дунд нь, яг хэрэгжих явц дунд нь ингэж зохицуулах ийм эрхээ авах ёстой. Тэр тохиолдолд хийж болно. Ойлгож байна, үнэхээрийн их, дээд сургуулиудын тэр 13 тэрбум тэр тогтмол зардал үнэхээрийн их, дээд сургуульд бодитой дэмжлэг байсан. Энэ нь бүр Дээд боловсролынхоо хуулийн 30 хэд билээ, 32.3 дээрээ бүр заачихсан зүйл. Тэгээд энэ яг хэрэгжих болоод ирсэн чинь хагас жилээр нь ингээд гүйцэтгэлээр нь олгоно гэж байгаад 5,8 нь ингээд хасагдаж байгаад би үнэхээрийн харамсаж байгаа. Гэхдээ энэ нь нэгэнт гэрээ байгуулагдсан

бараа, үйлчилгээ гэдэг энэ хэсэг рүү нь ороод ингээд эхэлбэл энэ өөрөө болохгүй. Эсвэл та бүхэн томьёоллоо төсөв дотроо хөдөлгөж, энэ асуудлыг шийдвэрлэ гэсэн байдлаар, арай болохгүй юу. Манай энэ юунаас ТНБД хариул даа.

Д.Рэгдэл: 5 дугаар микрофонд Батжаргал дарга хариулах юм байна.

Ж.Батжаргал: Бид Сангийн яамтайгаа энэ хасагдаж байгаа 170 тэрбум урсгал зардлаас хасагдаж байгаа. Яг энэ хүрээндээ яг дотроо зохион байгуулалт хийгээд хасах энэ зохицуулалтаа хийхээр ярилцаад байгаа л даа. Одоо яг шууд яг тэрийг, тэрийг бүр нарийвчлан заагаад, цалингаас жишээ нь тэдэн хүнийг яг тийм албан тушаалтныг хасна, цомхотгоно гэсэн асуудлууд байхгүйтэй адилхан зохицуулалтаа бол хийнэ гэж байгаа. Гэхдээ 13 тэрбумыг гаргаж ирж, бусад асуудлаас нь хасаад гаргаж ирнэ гэдэг бол туйлын хүнд байдалд орно гэсэн үг.

Д.Рэгдэл: Энэ чинь 13 тэрбум, тийм 5,8 тэрбум гэсэн юм байна шүү дээ Батжаргал даргаа. Бараа, үйлчилгээний бусад зардлаас 5,8 тэрбумыг хасаад, төрийн өмчит дээд боловсролын байгууллагын тогтмол зардалд шилжүүлнэ л гэсэн. Энэ ямар нэг эцэс төгсгөлгүй болгоод яах вэ. Ерөнхийдөө бүх талын тайлбар, томьёоллыг сонслоо. Гишүүд өөрийнхөө ухамсраар саналаа өгчих. Нэгэнт санал хураалгах ёстой гэж байна. Санал хураалт. Байнгын хорооны хуралдаанаар санал дэмжигдсэнгүй 38,5 хувийн саналтай байна. Ингээд зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа. Төсвийн тодотголын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Хосбаяр Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулна.

20.04 цаг

Байнгын хорооны хуралдаан хэлэлцэх асуудлаа дууслаа. Хуралдааныг хаасныг мэдэгдье. Хүрэлцэн ирсэн гишүүддээ их баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА